# ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААС ГАРСАН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

## 2017 онд гарсан шийдвэрийн хэрэгжилт

| № | Хуралд-сан огноо, дугаар | Хэлэлцсэн асуудал | Гарсан шийдвэр | Хариуцах газар, албан тушаалтан | Хэрэгжилт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | 2017.01.07 №01 | Тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хийсэн шалгалтын дүнгийн тухай | 5. Тээвэр зуучийн тухай хуулийн үзэл баримтлалыг боловсруулж Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар /Р.Мэргэн/-т, Төмар зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Артур/-т; | БТГ, ТЗДТБХЗГ | **БТГ:** Төмөр замын тээврийн тухай, Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тээвэр зуучийн асуудлыг тусгай бүлэг болгон тусган оруулсан. Иймд цаашид Тээвэр зуучийн тухай тусгайлсан хууль шаардлагагүй гэж Ажлын хэсгээс үзсэн болно.<br>Автотээврийн тухай хуулиийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын 2019 оны намрын чуулганаар хэлэлцүүлэхээр Ажлын хэсэг байгуулагдаад байна.<br>Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нэр томъёоны тайлбарт нэмэлт оруулах болон зарим нэг зохицуулалт нэмэх шаардлагатай тул уг төслийг 2019.09.07-ны өдрийн 02/4720 албан бичгээр буцаан татсан.<br>**Хэрэгжилтээс хасуулах саналтай байна.**<br><br>**ТЗДТБХЗГ:** Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоооос тавьж буй саналаар Тээвэр зуучлалын үйл ажиллагаа нь зөвхөн төмөр замаас гадна бусад салбарын үйл ажиллагаатай нягт уялдаатай байдаг тул Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа гэж дангаар ойлгох, журам боловсруулах нь өрөөсгөл тул энэхүү журмаас урьтаж хууль боловсруулж батлуулах шаардлагатай байгааг талаар санал дэвшүүлсэн.<br>Тээвэр зуучийн тухай хуулийн талаар судалгаа хийж ОХУ-ын холбогдох хуулийг судалсан. Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны журмын төслийг боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 264 дүгээр тушаалаар батлуулсан тул хэрэв хуулийн төсөл хийгдвэл төмөр замын салбараас оруулах чиглэл бэлэн болсон гэсэн үг. | 70 |
| 2 | 2017.01.07 №03 | Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 142.36 км хатуу хучилттай авто замын хяналтын | "Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 142.36 км хатуу хучилттай авто замын хяналтын зөвлөхийн хөрөнгийн асуудлаар Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Доржханд Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав. | Д.Доржханд /АЗБХЗГ-ын дарга/ | Чойбалсан чиглэлийн 142.36 км авто замын хяналтын зөвлөх "Эм Си Пи Си Жи Ар"/MCPC GR/ХХК-ийн шүүхэд нэхэмжлэл гаргасан зохиогчийн хяналтын зардлын нэхэмжлэлийг татуулж, зөвлөхийн хяналтын зардлыг шийдвэрлэх тухай №83 дугаартай эвлэрлийн гэрээ байгуулагдаж, Захиалагч үүргээ биелүүлээгүй, зөвлөхийн зардлыг шийдвэрлэж өгөөгүй талаар MCPC-аас албан тоот ирсэн. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | зөвлөхийн хөрөнгийг шийдвэрлэх тухай | Танилцуулгатай холбоотойгоор Зам, тээврийн хөгжлийн яам болон Эм Си Пи Си Жи Ар ХХК-ийн хооронд үүссэн шүүхийн маргаантай асуудлууд дээр харилцан тохиролцож уг асуудлыг удирдлагад танилцуулсны үндсэн дээр Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 142.36 км хатуу хучилттай авто замын хяналтын зөвлөхийн санхүүжилт болон нэмэлт гэрээний асуудлыг шийдвэрлэхийг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/-т даалгав. | | Үүний дагуу хуулийн хэлтэст тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хуулийн дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн.<br><br>Хуулийн хэлтсээс ЗТХСайдын зөвлөлийн 2017.01.07-ны өдрийн 03 дугаар тэмдэглэл, 2017.04.05-ны өдрийн 83 дугаартай эвлэрлийн гэрээг үндэслэл болгон 2020 оны Улсын төсөвт тусгах нь зүйтэй гэж үзсэн. Иймд ХОУХ-т тус авто замын хяналтын зөвлөхийн зардлыг 2020 оны төсөвт тусгах саналыг хүргүүлсэн. | |
| 3 | 2017.01.07 №04 | Монгол Улсын Хөгжлийн банк, Улсын төсөв, Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжсэн болон хэрэгжиж буй авто зам, гүүрийн барилгын болон зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн Ажлын хэсгийн тайлангийн тухай | 5.Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км хатуу хучилттай авто замын үлдэгдэл ажилд зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-тай байгуулж, нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэх; | Д.Доржханд /АЗБХЗГ-ын дарга/ | Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км хатуу хучилттай авто замын үлдэгдэл ажил болох 7.6 км авто замын хяналтын зөвлөх үйлчилгээг 33.5 сая төгрөгийн төсөвт өртгөөр үзүүлэхээр “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-тай 2018 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 101 дугаартай гэрээг байгуулж, ажилласан. | 100 |
| | | | 6. Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Үүрийн голын 350 у/м төмөрбетон гүүрийн барилга угсралтын ажилд гарсан технологийн алдаанаас үүсэх эрсдэлийг хэрхэн арилгах талаар хөндлөнгийн шинжээч томилон ажиллуулах, шинжээчийн дүгнэлтийг үндэслэн улсын комисс ажиллах асуудлыг шийдвэрлэх; | Д.Доржханд /АЗБХЗГ-ын дарга / | Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Үүрийн голын 350 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлын явц 100%-тай байна.<br>Гүүрэнд илэрсэн гажилтын улмаас гүүрийг ашиглалтад оруулах улсын комисс ажиллаагүй, ашиглалтанд хүлээж аваагүй байна.<br>Гүүрэнд гарсан хэв гажилтын талаар дүгнэлт гаргах ажлын хэсэг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ дээр байгуулагдаж, газар дээр нь ажилласан бөгөөд гүүрийг засах аргачлал, цаашид ашиглахтай холбоотой асуудлыг Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэх санал дүгнэлтийг ирүүлсэн.<br>Зохиогчийн хяналтын дүгнэлт гарсан. Хөндлөнгийн шинжээчийн баг томилж, газар дээр нь ажиллуулахаар шийдвэрлэсэн.<br>Цагаан-Үүрийн гүүрийг Статик, динамик ачааллал оруулан барилгын ажлын чанар байдалд дүгнэлт гаргах ажлыг ШУТИС-ын Оношлогоо, зураг төсөл, судалгааны төвөөс газар дээр нь хэмжилт хийсэн, дүгнэлтийг гаргаж ирүүлсэн бөгөөд ХШҮДАГ-т өгсөн.<br>ХШҮДАГ-аас гүйцэтгэгч “Хөвсгөл зам” ХХК-иас тайлбар ирүүлэхийг хүссэн боловч хариу ирүүлээгүй.<br>Холбогдох журмын дагуу ХШҮДАГ-аас гүүрийг ашиглалтад авах эсэхэд дүгнэлт гаргана. | 70 |
| | | | 3. Бусад байгууллага, иргэнтэй гэрээ байгуулсан гэрээг дүгнэх, гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний зөрчил бүхий асуудал тус бүрээр хууль, хяналтын байгууллагад | Л.Бямбасүрэн /ИНЕГ-ын дарга/ | ИНЕГ: 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 114 гэрээний төслийг хууль тогтоомжид нийцүүлэн хянаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. 2017 оноос өмнө байгуулсан гэрээний хэрэгжилтийн талаар маргаантай байгаа ”Мобиком корпораци” ХХК, “Монголын цахилгаан холбоо” ХХК, “Хасу энержи” ХХК, “Уран өнгө” ХХК, “Электрон системс” ХХК-тай холбоотой асуудлууд шүүхийн шатанд хянагдаж байна. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хандан шийдвэрлүүлж, байгууллагад учруулсан хохирлыг арилгуулах; | | Үнээс "Мобиком корпораци" ХХК болон "Монголын цахилгаан холбоо" ХХК-ийн нэхэмжлэлтэй иргэний хэргүүд дээр талууд харилцан зөвшилцөж, эвлэрлийн гэрээ байгуулан хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлсэн.Байгууллагын зардлаар суралцагчтай байгуулсан гэрээний маргаантай Ж.Лхамсүрэн, О.Намбат нарын нэхэмжлэлтэй хэрэг анхан шатны шүүхэд хянагдаж байна.Хэдийгээр гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотойгоор шүүхэд маргаантай байгаа боловч олон жил удаашралтай хүлээгдэж буй Завхан аймгийн "Доной" нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвас, Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын ажлуудыг яаралтай гүйцэтгүүлж, ашиглалтад оруулах үүднээс "Үүрэг трейд" ХХК, "Хурдны зам" ХХК-иудтай нэмэлт гэрээ байгуулсан. | |
| | | | **Гурав.** Технологийн бодлогын хүрээнд:<br><br>1. Ховд нисэх буудлын аэродромыг 4С ангиллын болгосон хөөрч буух зурвасын хучилтын даацыг техникийн аргаар тодорхойлох асуудлыг мэргэжлийн баг гаргаж, дүгнэлт гаргуулах; | Л.Бямбасүрэн /ИНЕГ-ын дарга/ | 2017.05.18-24-ны өдрүүдэд Ховд нисэх буудалд аэродромын инженер томилон ажиллуулж хөөрч буух зурвасын хучилтын байдлын үнэлгээг урьдчилсан байдлаар гаргасан.<br>Хөөрч буух зурвасын хучилтын даацыг 2017 оны 07 дугаар сарын 21-нд хэмжиж, тайланг 08 дугаар сарын 21–нд НААХЗА-д хянуулахаар хүргүүлсэн.<br>Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагчийн 2017 оны 770/17 дугаар дүгнэлтээр Хөөрч буух хучилттай зурвасын гадаргуугийн ашиглалтын байдлын үнэлгээг /ХБХЗ.PCI-41, ЯЗ.PCI-44, Перрон PCI-54/ хянаж, ашиглалтын байдлын үнэлгээг шинэчлэн тодорхойлох шаардлагыг гэрчилгээ эзэмшигч Ховд нисэх буудал болон НБУГ-т хүргүүлсэн.<br>2018 оны 03 дугаар сарын 05-09-нд БНХАУ-ын тусгай бүс Хон Конгод "Airfield Pavement Design" сургалтад "Чингис хаан" ОУНБ-ын Аэродромын албаны 1 инженерийг хамруулж, гэрчилгээжсэн бөгөөд Аэродромын хучилтын даацыг техникийн аргаар үнэлэх боломжтой болсон.<br>2018 оны 6 дугаар сард хэмжилтийг хийж, тайланг НААХЗА-нд хүргүүлсэн.<br>НААХЗА дахин хянах үүрэг өгсөн. Орон нутгийн нисэх буудлуудын аэродромын ашиглалтын түвшинг тогтоох зардал 2019 оны төсөвт суугаагүй тул уг ажил бүрэн хэрэгжээгүй.<br>2020 онд тус нисэх буудлуудын аэродромын ашиглалтын түвшинг тогтоох төлөвлөгөөг НБУГ-ын даргаар 2019.11.06-ны өдөр батлуулсан. Хөрөнгийг 2020 оны төсөвт төсөлд суулгасан. 2020 оны 6 дугаар сараас хэмжилтийг хийнэ. | 70 |
| | | | 2. Аэродромын хучилтын даацыг тодорхойлоход техникийн аргачлалыг нэвтрүүлэх, хэмжилтийг гүйцэтгэх туршилт, судалгааны лабораторитой болох; | Л.Бямбасүрэн /ИНЕГ-ын дарга/ | Аэродромын хучилтын даацын техникийн аргачлалыг нэвтрүүлэх, хэмжилтийг гүйцэтгэх, туршилт, судалгааны лабораторийн багаж тоног төхөөрөмж болон гадаргуунаас дээж авах тоног төхөөрөмжийн судалгааг гаргасан.<br>Улаанбаатар хотын шинэ нисэх буудлын барилга угсралтын ажлын гүйцэтгэгч "Samsung" компанийн ашиглаж байсан лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг хүлээж авахаар төлөвлөж байсан боловч тус лабораторийг Авлигатай тэмцэх газраас битүүмжилсэнтэй холбогдуулан лабораторитой болох ажил удааширсан. | 30 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Иймд аэродромын лабораторитой болгох асуудлыг ЗТХЯ-ны Шинжлэх ухаан технологийн 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 6 дугаар хурлаар хэлэлцүүлж, лабораторитой болох нь зүйтэй гэж шийдвэр гаргасан. | |
| | | | 3. Бага, дунд оврын агаарын хөлгийн нисгэгч бэтгэх сургалтын хөтөлбөрийг Олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, Олон улсын иргэний нисэхийн байгууллагаар батлуулах ажлыг зохион байгуулах; | Л.Бямбасүрэн /ИНЕГ-ын дарга/ | Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын гишүүн орны хувьд Чикагогийн конвенц, ОУИНБ /ICAO/-аас гаргадаг зөвлөмжийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байдаг.<br>ИНД-141-ийн шаардлагын дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллага нь өөрийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, ИНЕГ-ын НААХЗА-аар батлуулснаар үйл ажиллагаагаа эхлүүлэх боломж бүрддэг.<br>Иймд дээрх сургалтын хөтөлбөрийг боловсруулах нь ИНД-141-ээр гэрчилгээжсэн байгууллагын үүрэг бөгөөд түүнийг Иргэний нисэхийн ерөнхий газар нь ИНД-141-ийн дагуу сургалтын хөтөлбөрийг баталдаг.<br>Мөн хувийн нисгэгч бэлтгэх анхан шатны сургалтын төвүүд байгуулагдаж гэрчилгээжсний дараа тухайн байгууллага сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулах болно. Иргэний нисэхийн ерөнхий газар уг асуудлыг хариуцахгүй тул энэхүү ажлыг хяналтаас хасуулах саналтай байна. | 70 |
| | | | 4. Монгол Улсын агаарын зам, агаарын орон зайн ашиглалтыг сайжруулж агаарын хаалга, өнгөрөлтийн нислэгийг нэмэгдүүлэх, нислэгийн хөдөлгөөний бүсийн удирдлагын шинэ төвийн байрыг ашиглалтад оруулах асуудлыг шийдвэрлүүлэх; | Л.Бямбасүрэн /ИНЕГ-ын дарга/ | 1. Монгол Улсын агаарын зам, агаарын орон зайн ашиглалтыг сайжруулж агаарын хаалга, өнгөрөлтийн нислэгийг нэмэгдүүлэх:<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн “Агаарын замуудыг шинэчлэн тогтоох тухай” 09 дүгээр тушаалаар Монгол Улсын агаарын зайд үзүүлэлтэд тулгуурласан навигаци бүхий замуудыг шинэчлэн тогтоож 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж эхлээд байна. ИНЕГ-ын даргын 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/763 дугаар тушаалаар Тэргүүн дэд дарга Б.Алтанцомоор ахлуулсан дэд ажлын хэсгийг томилж, агаарын зайн ашиглалтыг сайжруулах, нислэгийн өнгөрөлтийн тоог нэмэгдүүлэх ажлуудыг гүйцэтгэсэн. **Үүнд:**<br>**1.** БНХАУ-ын Бээжин, Чэнгдү хотууд болон тэр бүс нутгийн агаарын зайн ачаалал өндөр байдаг. Үүнээс шалтгаалан тус бүс нутгаар дайран манай улсыг дамжин нисдэг зарим нислэгүүдийг манай улсын зүүн болон баруун хилийн цаагуур шууд БНХАУ-Казахстан, БНХАУ-ОХУ-ыг холбосон агаарын замаар нисгэж байна. Энэ шалтгааны улмаас БНХАУ-тай шинээр 2 агаарын хаалга нээхээр төлөвлөн ажиллаж байна. БНХАУ-ын НХУГ-ын төлөөлөгчидтэй 2017 оны 11 дүгээр сарын 9-10-нд уулзаж, баруун талд агаарын зам шинээр нээж ашиглах талаар ярилцсан. Хятадын тал NIXAL ба SARUL цэг рүү хоёр агаарын замаар холбогдох шинэ агаарын хаалга нээх санал тавьсан бол монголын тал хоёр шинэ агаарын хаалга нээх санал тавьсан.<br>БНХАУ-ын тал шинэ агаарын хаалга нээх асуудал нь цэргийн нисэхийн байгууллага гэх мэт төрийн хэд хэдэн байгууллагын шийдвэр, харилцан | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагаанаас хамааралтай нарийн нийлмэл асуудал учир ихээхэн цаг хугацаа зарцуулах болохыг мэдэгдсэн.<br><br>2.Агаарын навигацийн хураамжийн аргачлалыг боловсронгуй болгож, ИНЕГ-ын даргын 2017 оны А/ 266 дугаар тушаалаар баталж, мөн оны 7 дугаар сарын 01-нээс шинэчилсэн хураамжийг мөрдөж эхэлсэн.<br>3.Монгол Улсад иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын замуудыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 04-ний 60 дугаар тушаалаар батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсэн бөгөөд ИНЕГ-ын даргын 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн А/431 дүгээр тушаалаар 2019 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн үйл ажилаагаанд ашиглаж байна. .Монгол Улсын агаарын зайг тогтоох, нисэх буудлуудын хяналттай агаарын зай, босоо болон хэвтээ хязгаарыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 119 дүгээр тушаалаар батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсэн бөгөөд ИНЕГ-ын даргын 2019 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/510 дугаар тушаалаар 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрөөс үйл ажиллагаанд ашиглаж байна. 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар Монгол Улсын агаарын зайд нийт 141774 нислэг гүйцэтгэгдсэн байна. Үүнд:<br>● Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо - 124737<br>● Буулт, хөөрөлтийн тоо- 9510<br>● Орон нутгийн нислэгийн тоо-7527 байна.<br>Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад олон улсын өнгөрөлтийн нислэг-8.8%-иар, буулт, хөөрөлт- 19.9%-иар, орон нутгийн нислэг -25.1% -иар тус тус өссөн дүнтэй байна.<br>2.ИНЕГ-ын Бүсийн нислэг хөдөлгөөний удирдлагын төвийн барилга:<br>2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр “Үүрэг трейд” ХХК- тай гэрээг шинэчлэн байгуулсан. Барилгын ажлын явцад 2018/01/18-ны өдөр баталсан Барилга, хот байгуулалтын сайдын 10 дугаар тушаалаар БНД-д нэмэлт, өөрчлөлт орсноор барилгын гал унтраах системийг шинэчлэх шаардлага гарсан. Барилга угсралтын ажил гэрээний дагуу 2019 оны 9 дүгээр сарын 30-ний өдөр дуусгаж, 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс Техникийн комисс ороход бэлэн болгохоор төлөвлөж байна. Гэрээний хэрэгжилтийг хурдасгах зорилгоор дараах ажлууд хийгдэж байна. **Үүнд:**<br>✓ Барилга угсралтын ажилд Захиалагчийн талаас хяналтын инженер давхар томилсон.<br>✓ ИНЕГ-ын даргын 2019 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А/750 дугаар тушаалаар “Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилт, өдөр тутмын үйл ажиллагаа, батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах” ажлын хэсгийг томилсон.<br>2019 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар г**адна ажил** 98%-тай, **дотор засал** А, В, Д блок 90 хувьтай, нийт гүйцэтгэл 94%-тай байна.“Барилгын ажлыг мөн оны 10 дугаар сарын 5-ны өдөр дуусгаж, 10 дугаар сарын | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 20-нд Техникийн комиссыг ажиллуулахаар, 10 дугаар сарын 30 өдөр Улсын комиссыг ажиллуулахаар төлөвлөж байна. | |
| | | | **Дөрөв.** Санхүү, хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд:<br><br>Тухайн жилийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын хуваарилалтыг хийхдээ үндсэн үйлдвэрлэл, аюулгүй ажиллагаа доголдохоос сэргийлж, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, үр ашигтай байх бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын жишгийн дагуу бүрдүүлэх; | Л.Бямбасүрэн /ИНЕГ-ын дарга/ | Үндэсний аудитын газрын 2017 оны 03/16, САГ-2017/22/СТА-ТТЗ дугаартай актад тусгагдсан Сургалтын төлбөрийн тэтгэмжид олгосон 6.300.000 /зургаан сая гурван зуун мянга/ төгрөгийг буцаан төлүүлэхээр уг тэтгэмжийг олгохоор шийдвэрлэсэн. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2016 оны А/48 дугаар тушаалыг хүчингүй болгосон. Тушаал хүчингүй болсонтой холбогдуулан тэтгэмж авсан ажилтнаас олгосон мөнгийг буцаан гаргуулахаар холбогдох арга хэмжээг авсан. | 70 |
| | | | 1. Санхүүгийн сахилга батыг сайжруулах, хувь хүмүүстэй холбоотой үүссэн авлагыг барагдуулах, найдваргүй төлөгдөх боломжгүй болсон авлага, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар бусаар зарцуулсан асуудлыг хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх; | Л.Бямбасүрэн /ИНЕГ-ын дарга/ | Батлагдсан төсвийн дагуу тухайн жилийн үйл ажиллагааны зардлыг харьяа байгууллага бүрээр хуваарилан харьяа алба, салбаруудад хүргүүлж, мөрдөж байна.<br>Нийт 31 хэрэг хууль хяналтын байгууллагад хянагдаж байна. **Үүнд:**<br>Авлигатай тэмцэх газарт хянагдаж буй: **2;**<br>Шүүхэд хянагдаж буй маргаан нийт: **20** /анхан шатанд: 12, давж заалдах шатанд: 5, хяналтын шатанд: 4/<br>Хувь хүнтэй холбоотой: 20<br>Хуулийн этгээдтэй холбоотой: 9<br>2019 онд шийдвэрлэгдсэн: **8**<br>Өмнөх оны мөн үетэй харьцуулахад шүүх, хууль хяналтын байгууллагаар хянагдаж байгаа маргаантай асуудал 2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | 70 |
| | | | 3. Орон сууцны хөнгөлөлтийн болон гадаад, дотоод томилолтын журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх, хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог бий болгохыг тус тус үүрэг болгов. | Л.Бямбасүрэн /ИНЕГ-ын дарга/ | Орон сууцны үнийн хөнгөлөлт олгох журамд тусгагдсан зохицуулалтыг шинэчлэн боловсруулсан. Хөдөлмөрийн дотоод журамд нэг бүлэг болгон оруулж, дотоод журмын төсөлд тусгасан. “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг ИНЕГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/803 дугаар тушаалаар баталсан.<br><br>“Гадаад, дотоод томилолтын журам” -ыг ИНЕГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын21-ний өдрийн А/854 дүгээр тушаалаар баталсан. | 100 |
| 6 | 2017.03.31 №10 | Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн талаарх | Авто зам, замын байгууламж барих, засварлах тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж байгууллагуудад хийсэн хяналт шалгалтын дүнгийн тухай Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гомбосүрэн танилцуулав. Танилцуулгатай холбоотойгоор судалгааны ажлын | ХШҮДАГ | **ХШҮДАГ.**<br>Танилцуулгатай холбоотойгоор судалгааны ажлын чанар, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлтийг дахин боловсруулах тухай зөвлөмжийн улсын хэмжээнд бүртгэлтэй байгаа нийт 564 аж ахуй нэгж, байгууллагуудын бүртгэлийг гаргаж чадавхын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр авто замын салбарт тусгай зөвшөөрөл эзэмшигч нарыг аж ахуйн нэгж байгууллагын чадавхын мэдээллийг 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлэх тухай зарыг Яам, “МАЗХ” ТББ-ын мэдээллийн сайтуудад | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | дүгнэлтийн тухай | чанар, цаашид авах арга хэмжээний санал, үндэслэлийг сайжруулах шаардлагатай тул тус асуудлыг хойшлуулж Сайдын зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т даалгав | | байршуулсан бөгөөд мэдээллийн дагуу хугацаандаа буюу 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хүртэл 208 аж ахуйн нэгж байгууллагууд материалаа ирүүлсэн.<br>Мөн АЗБХЗГ-т Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахаар хүсэлт ирүүлсэн байгууллагуудын материалыг авч нэгтгэв.<br>Нийт 564 ААНБ-аас 267 ААНБ-н холбогдох материал ирүүлснийг нэг бүрчлэн нягтлан үзэж, чадавхын мэдээллийг өмнө бүрдүүлсэн мэдээллийн сантай тулгаж, сүлжээнд оруулан мэдээллийн санг шинэчлэх ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>2018 онд авто замын засвар арчлалтын .. компаний үйл ажиллагаанд болон улсын төсвийн зарцуулалтын байдалд санхүүгийн хяналт, шалгалт хийсэн. 2019 онд үлдсэн компанид шалгалт хийж дууссаны дараа нэгдсэн дүнг Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ. | |

## 2018 онд гарсан шийдвэрийн хэрэгжилт

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | 2018.01.08 №5 | УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Зам, тээврийн хөгжлийн сайдад өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд 2017 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан | 1. Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Усан замын тээврийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан эдгээр хуулиудаар эрх зүйн акт /дүрэм, журам, заавар/ батлахаар эрх олгогдсон заалтуудад заасан дүрэм, журмыг шинэчлэх болон шинээр боловсруулах ажлыг эрчимжүүлж, 2018 оны эхний хагас жилд багтаан батлуулахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/-т; | Д.Доржханд /АЗБХЗГ-ын дарга/ | ТНБД 2017.06.23-ны өдрийн 191 дугаар тушаалаар Авто замын хуультай холбогдуулан 16 журам боловсруулах ажлын хэсгүүд байгуулагдсан. Дээрх журмуудаас 2 журмын төсөл буюу “Авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдалд үзлэг, шалгалт хийх, үр дүнг боловсруулах журам” болон “Магадлашгүй ажлын зардлыг тооцож олгох журам”-уудыг тус тус батлуулах шаардлагагүй гэж үзсэн бөгөөд нийт 14 журмын төсөл боловсруулах ажлын явц дараах байдалтай байна.<br><br>**Батлагдсан журмууд: 12**<br>1.“Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”<br>2.“Авто замын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох журам”<br>3.“Авто зам, замын байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам”<br>4.“Авто замын норм, нормативын сангийн ажиллах журам”<br>5.“Авто зам, замын байгууламжийг хаах, замын чиглэл өөрчлөх журам”<br>6.“Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам”<br>7. “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”<br>8. “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам”<br>9. “Авто замын хөдөлгөөний эрчмийн тооллого хийх, үр дүнг боловсруулах журам”<br>10.“Авто замын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам”.<br>11. “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 12.“Олон улс, улсын болон тусгай зориулалтын авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журам”-ын төсөл<br><br>”Боловсруулаах болон батлагдах шатанд байгаа журмууд: 2<br>1.“Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэх журам”<br>2.“Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын төсөл<br>Журмын төслүүдийг боловсруулах ажлын биелэлт 90%-тай байна. | |
| | | | | ТЗДТБХЗГ | “Усан замын тээврийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтад “усан замын сүлжээн дэх улс болон аймаг хоорондын тээвэрлэлтийн чиглэлийг батлах” гэж заасан ч өнөөгийн байдлаар улс хооронд болон аймаг хооронд хийгдэж буй усан замын тээврийн үйлчилгээ байхгүй.<br>Улс хооронд Сэлэнгэ мөрнөөр усан замын тээвэр хийх асуудлаар ОХУ-ын талд санал хүргүүлсэн боловч ОХУ-ын нутаг дэвсгэрт 100 гаруй км /Сэлэнгэ мөрөнд усан замын тээврийн хэрэгсэл зорчих байгалийн нөхцөл нь боломжгүй гэсэн хариуг ОХУ-ын зүгээс 2014-2016 онд өгсөн.<br>Мөн 2 улсын хооронд шинээр усан хилийн боомт нээх, /боомт нээх асуудлыг 2 улсын Засгийн газар, УИХ-ын түвшинд хэлэлцэж байж шийдвэр гарна/, тэнд ажиллах 2 улсын хил, гаалийн ажилтнуудын амьдрах нөхцлийг бүрдүүлэх зэрэг их хэмжээний зардал чирэгдэл гарах тул боломжгүй гэсэн хариуг өгсөн билээ.<br>Аймаг хооронд усан замын тээвэр хийх байгалийн нөхцөл нь боломжгүй.<br>Хуулийн энэүү заалтын дагуу 3 дүрэм, 3 журмыг шинээр боловсруулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн улс даяар дагаж мөрдүүлэв. **Үүнд:**<br><br>1. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм; /шинээр/<br>2. Усан замын обьект болон усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм; /шинээр/<br>3. Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм. /шинээр/<br>4. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам; /өөрчлөлт/<br>5. Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой обьектод гэрчилгээ олгох журам; /шинээр/<br>6. Усан замын тээврийн боловсон хүчин, тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам; /шинээр/<br>7. Усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам /Өөрчлөх, шинэчлэх шаардлагагүй/ | 100 |
| 7 | 2018.01.08 №8 | “Дугуйт тээврийн хэрэгсэл болон тэдгээрт ашиглаж болох | “Дугуйт тээврийн хэрэгсэл болон тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж болон эд ангид зориулсан техникийн | С.Батболд /АТБХЗГ-ын дарга/ | **БТГ, СНХ:** “Дугуйт тээврийн хэрэгсэл болон тэдгээрт ашиглаж болох тоног, төхөөрөмж болон эд ангид зориулсан техникийн нэгдсэн шаардлагыг батлах тухай хийгээд эдгээр шаардлагад үндэслэн олгосон зөвшөөрлийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр” /1995 онд | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тоног, төхөөрөмж болон эд ангид зориулсан техникийн нэгдсэн шаардлагыг батлах тухай хийгээд эдгээр шаардлагад үндэслэн олгосон зөвшөөрлийг харилцан хүлээн зөвшөө-рөх тухай хэлэлцээр /1958 оны хэлэлцээрт 1995 онд нэмэлт, өөрч-лөлт оруулсан/-т нэгдэн орох тухай | нэгдсэн шаардлагыг батлах тухай хийгээд эдгээр шаардлагад үндэслэн олгосон зөвшөөрлийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр"-т нэгдэн ороход шаардагдах бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр гарын үсэг зурах нь зүйтэй гэж үзэв." гэжээ. | Үүрэг АТБХЗГ-т өгөгдсөн боловч БТГ-ын СНХэлтэс уг ажлыг гүйцэтгэж байгаа | нэмэлт, өөрчлөлт оруулсан/-т нэгдэн орох тухай ЗГ-ын тогтоол, үзэл баримтлал, хуулийн төсөл, танилцуулгыг боловсруулан Гадаад харилцааны яаманд 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн "Үзэл баримтлалын төсөлд урьдчилан санал авах тухай" 03/2809 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Үзэл баримтлалыг ГХЯ-аар батлуулж, Хууль зүй, Дотоод хэргийн яаманд 2018 оны 01/4997 албан бичгээр хүргүүлээд бөгөөд ХЗДХЯ-наас "Хэлэлцээр соёрхон батлах тухай" хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй хэмээн 2018 оны 1-1/5362 дугаартай албан бичгээр зөвлөмж, чиглэл өгсөн тул дахин боловсруулж байна.<br>**АТБХЗГ**: "Дугуйт тээврийн хэрэгсэл болон тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж болон эд ангид зориулсан техникийн нэгдсэн шаардлагыг батлах тухай хийгээд эдгээр шаардлагад үндэслэн олгосон зөвшөөрлийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр"-т нэгдэн ороход шаардагдах бэлтгэл ажлыг хангах холбогдох судалгаа, бэлтгэл ажил хийгдэж байна.<br>Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яамнаас санал авч үзэл баримтлалыг дахин боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн сайдын үүрэг гүйцэтгэгч, Шадар сайд Ө.Энхтүвшингээр батлуулан 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/4641 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Үзэл баримтлалыг ГХЯ-аар батлуулж, Хууль зүй, Дотоод хэргийн яаманд 2018 оны 01/4997 албан бичгээр хүргүүлсэн бөгөөд ХЗДХЯ-наас "Хэлэлцээр соёрхон батлах тухай" хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй хэмээн 2018 оны 1-1/5362 дугаартай албан бичиг ирүүлсэн.<br>Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нийцүүлэн "Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаа, нэр томьёо, тодорхойлолт, хэмжээ, жин, даац зэрэгт тавих ерөнхий шаардлага"-ын үндэсний эрх зүйн баримт бичиг "техникийн зохицуулалт"-ын төслийг дээрх хэлэлцээрийн хавсралтууд болон Европын эдийн засгийн комиссоос баталсан техникийн шаардлага, удирдамж, зөвлөмжид нийцүүлэн боловсруулж байна. | |
| 8 | 2018.01.08 №09 | Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай | Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Батболд танилцуулав. Хуулийн төслийг хэлэлцээд дахин боловсруулж сайжруулах шаардлагатай тул тус асуудлыг хойшлуулж Сайдын зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцүүлэхийг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Батболд/-т даалгав".гэжээ. | С.Батболд /АТБХЗГ-ын дарга/ | Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийг өргөн барихад шаардлагатай дагалдах судалгаа, нөлөөллийн шинжилгээ, хуулийг хэрэгжүүлснээр гарах үр ашиг, зардлын тооцоог "СИВИКО" консалтинг компаниар гүйцэтгүүлж 2017 оны 12 дугаар сард хүлээн авсан. Хуулийн төслийг 2018.01.09-ны өдрийн Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг ХЗДХСайд болон ЗТХСайдаар 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдөр батлуулав.<br>Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын 2019.03.27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, 2019.04.24-ны өдөр УИХ-ын даргад өргөн мэдүүлэв.<br>УИХ-ын 2019.05.31-ны өдрийн нэгдсэн чуулганаар Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхийг дэмжив. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11 | 2018.04.06 №13 | Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төслийн тухай” | 2. “Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын үзэл баримтлалын төслийг дэмжив. Сайдын зөвлөлийн гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийг тусган батлуулахыг Бодлого төлөвлөлтийн газар /Р.Мэргэн/-т, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/-т тус тус даалгав.” | ТЗДТБХЗГ | **ТЗДТБХЗГ:** Хуулийн үзэл баримтлалын төсөлд ЗТХЯ-ны газар, хэлтсүүдээс санал авахаар 2018.05.28-ны өдрийн дотоод албан бичгээр хүргүүлж, ирсэн саналыг судлан тусгасан.<br>Хуулийн үзэл баримтлалын төсөлд хуулийн хэлтсээс санал авахаар хүргүүлсэн.<br>Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчлэн найруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.08.06-ны өдрийн 163 дугаар тушаал, 197 дугаар тушаалаар тус тус шинэчлэн өөрчилсөн.<br>Мөн уг хуулийн төслийг эрчимжүүлэх зорилгоор Ажлын нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, ТЗДТБХЗГ-ын даргаар батлуулж, хуулийн төсөлд ирсэн саналуудыг тусган холбогдох өөрчлөлтийг оруулж байна. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт шинжилгээ хийх ажлын хүрээнд ЗТХЯ, “ГТХЗНТ” УТҮГ, “МТЗ” ТӨХК, “УБТЗ” ХНН, “БТЕГ” ХХК-ийн удирдах ажилтнууд, хууль, хяналтын чиг үүрэг бүхий нийт 110 ажилтан, албан хаагчдыг хамруулсан асуулгыг явуулж, хариуг авч нэгтгэн дүн шинжилгээ хийсэн.<br>Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран батлуулав.<br>Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд баталж, 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 1-1/294 тоот албан бичгээр ирүүлэв. | 100 |
| 14 | 2018.12.12 №15 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй хавсралтад дурдагдсан Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км Булган-Үенч-Ховд чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замуудын барилгын ажилд нэмж шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх талаар | “VI.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй хавсралтад дурдагдсан Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км Булган-Үенч-Ховд чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замуудын барилгын ажилд нэмж шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх талаар Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Доржханд Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав. Танилцуулгатай холбоотойгоор Сангийн яамнаас албан ёсоор чиглэл авч тус яамнаас зөвшөөрсөн тохиолдолд тухайн асуудлыг ажил хэргийн шугамаар шийдвэрлүүлэхийг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/-т даалгав. гэжээ | АЗБХЗГ | Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км Булган-Үенч-Ховд чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замуудын барилгын ажилд нэмж шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх асуудлыг Сангийн яаманд 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр танилцуулсан.<br>Сангийн яамнаас нэмэлт санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх боломжгүй хариуг өгсөн.<br><br>**/Хэрэгжилтээс хасах саналтай/** | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 15 | 2018.12.12 №16 | “Авто замаар олон улсын ачаа, зорчигч тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд зорчих зөвшөөрлийн бичиг олгох ажлыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийн талаар” | 1. БНХАУ-аас бусад “Автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр” бүхий улсууд уруу олон улсын ачаа, зорчигч тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд зөвшөөрлийн бичиг олгох ажлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэр гаргуулах нь зүйтэй гэж үзэв.<br>2. Холбогдох журмын дагуу шийдвэрийн төслийг бэлтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Сэрээтэр/, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Батболд/-т тус тус даалгав.” гэжээ. | Ж.Сэрээтэр /БТГ/<br><br>С.Батболд /АТБХЗГ-ын дарга/ | Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас бусад Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээр бүхий улс руу олон улсын ачаа, зорчигч тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд зөвшөөрлийн бичиг олгох ажлыг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулах 2019.01.10-ны өдрийн 01/103 дугаартай албан бичгээр яамдаас санал авсан.<br>Уг тогтоолын төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам зэрэг ерөнхий чиг үүргийн яамд болон Шадар сайдаас дэмжээгүй тул Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх боломжгүй болсон бөгөөд энэ талаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт мэдэгдэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтаас хасуулсан. | - |
| 16 | 2018.12.12 №17 | Тээврийн сайд нарын Европын бага хурлын талаарх протоколд нэгдэн орох тухай | 1. Тээврийн сайд нарын Европын бага хурлын талаарх протоколд нэгдэн орох нөхцлийг судлан, бэлтгэл ажлыг хангаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжив.<br>2. Тус протоколд элсэн орох асуудлуудтай холбоотой хууль, тогтоолын төслийн үзэл баримтлалыг боловсруулж, холбогдох танилцуулга, тооцоо, судалгааг нарийвчлан гаргаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэхийг Бодлого төлөвлөлтийн газар /Ж.Сэрээтэр/, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Батболд/-т тус тус даалгав” гэжээ. | Ж.Сэрээтэр /БТГ/<br><br>С.Батболд /АТБХЗГ-ын дарга/ | **БТГ:** Тээврийн сайд нарын Европын бага хурал (ECMT)-ын протокол ба үндсэн дүрмийг ГХЯ-аар орчуулуулж байгаа бөгөөд орчуулгын зардлыг “АТҮТ” ТӨҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны санхүүгийн төлөвлөгөөнд тусгуулан шийдвэрлэсэн.<br>Тээврийн сайд нарын Европын бага хурал (ECMT)-ын протокол ба үндсэн дүрмийг судлах, энэхүү бага хуралд элсэх боломж, нөхцлийг тодорхойлох чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах техник туслалцааны төслийг хэрэгжүүлэх саналыг бэлтгэн, тус яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд Олон улсын автотээврийн холбооны 2019-02-28-наас 2019-03-02-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан хурлын үеэр НҮБЕЭЗК болон ОУАТХолбоонд танилцуулан, дэмжлэг хүссэн.<br>Энэ ажлын хүрээнд Олон улсын автотээврийн холбооноос 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 10-ны өдрүүдэд “Аюултай ачаа тээвэрлэх тухай” олон улсын конвенци, Жолоочийн болон тээврийн хэрэгслийн багийн ажил амралтын горимын тухай /AETR/ хэлэлцээр, мөн “Ачааг аюулгүй ачих буулгах технологи” сэдвээр үндэсний хэмжээнд 16 сургагч багшийг МАТНХ-той хамтран бэлтгэлээ.<br>Мөн UNECE болон Олон улсын Автотээврийн Холбоотой хамтран дээрх чиглэлээр чадавхийг бэхжүүлэх сургалтыг 2019-06 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд уг сургалтаар 30 хүнийг сургасан.<br>“АТҮТ” ТӨҮГ-ийн Судалгаа, чанарын удирдлагын албатай хамтран энэ чиглэлийн судалгааны ажлыг хийж, сайдын зөвлөлийн хурлаар | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэлэлцүүлж шийдвэр гаргуулахаар 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр ТЗУГ-т хүргүүлсэн.<br>Тооцоог судалгааг хийж 2019.10.15-ны Сайдын зөвлөлийн 32 дугаар хурлаар оруулсан. Уг асуудлыг АТБХЗГ-аас Засгийн газрын хуралдаанаар оруулахаар болсон.<br><br>**АТБХЗГ:** Энэ ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн. **Үүнд:**<br>НҮБЕЭЗК болон ОУАТХ-той хамтран “National TIR seminar”сургалтыг 2019-06-18-19-ний өдрүүдэдМонгол Улсад амжилттай зохион байгууллаа. Уг сургалтаар Тээврийн хэрэгслийн багийн ажил амралтын горим, Ногоон картын систем, ТИР тээвэрлэлт, eTIR чиглэлээр чадавхийг бэхжүүлж, нийт 35 хүнийг хамруулж, мэргэшүүлэв. Дээрх олон улсын сургалтуудыг Монгол Улсад зохион байгуулахад нийт 210 сая төгрөгийн техникийн туслалцааны хүрээнд олон улсын байгууллагуудаас шийдвэрлүүлсэн ба дотоодын нөөц бололцооны хүрээнд 11 сая төгрөгийн зарцуулав. Нийт 46 хүнийг энэ чиглэлээр мэргэжил дээшлүүлэв.<br>2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр тус яаман дээр зохион байгуулагдсан Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (OECD)-ын төлөөлөгчдийн “Улс орнуудын холболт” төслийн танилцуулгыг хийх уулзалтын үеэр МУ Тээврийн сайд нарын Европын бага хурал (ECMT) /хуучин нэрээр / буюу одоогийн Олон Улсын Тээврийн Форумд гишүүнээр элсэх хүсэлтэй байгаагаа илэрхийлж энэ чиглэлээр хамтран ажиллах дэмжлэгийг хүссэн. Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (OECD)-ын төлөөлөгчдийн зүгээс Олон Улсын Тээврийн Форумд элсэх чиглэлээр мэргэжлийн зөвлөмж, чиглэл өгч ажиллахыг дэмжсэн болно. Үүний дагуу 2019-09-11-ний өдөр Олон улсын тээврийн форумын Тээврийн судлаач Ольга Петрик нь мэдээлэл болон эрх зүйн бичиг баримтуудыг ирүүлсэн.<br>Судалгааны ажил дуусгавар болгож, энэхүү олон улсын байгууллагын гишүүнчлэлд элсэх эсэх асуудлыг ЗТС-ын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж 32 тэмдэглэл гарсан. Тэмдэглэлд элсэх асуудлыг дэмжив. | |
| 17 | 2018.12.12<br>№18 | Олон улсын авто замын тээвэр гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн багийн ажлын талаарх Европын хэлэлцээрт нэгдэн орох тухай | 1. Олон улсын авто замын тээвэр гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн багийн ажлын талаарх Европын хэлэлцээрт нэгдэн орох нөхцлийг судлан, бэлтгэл ажлыг хангаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжив.<br>2. Тус хэлэлцээрт нэгдэн орох асуудлуудтай холбоотой хууль, тогтоолын төслийн үзэл баримтлалыг боловсруулж, холбогдох танилцуулга, тооцоо, судалгааг нарийвчлан гаргаж, | Ж.Сэрээтэр<br>/БТГ/<br><br>С.Батболд<br>/АТБХЗГ-ын дарга/ | **БТГ:** Олон улсын авто замын тээвэр гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн багийн ажлын талаарх Европын хэлэлцээр /AETR/-ийн эх хувийг ГХЯ-аар орчуулуулан 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авсан. Орчуулгын зардлыг “АТҮТ” ТӨҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны санхүүгийн төлөвлөгөөнд тусгуулан шийдвэрлүүлсэн.<br>Олон улсын авто замын тээвэр гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн багийн ажлын талаарх Европын хэлэлцээр /AETR/-ийн чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах техник туслалцааны төслийг хэрэгжүүлэх саналыг бэлтгэн, тус яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд Олон улсын автотээврийн холбооны 2019-02-28-наас 2019-03-02-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан хурлын үеэр НҮБЕЭЗК болон ОУАТХолбоонд танилцуулан, дэмжлэг хүссэн.<br>Энэ ажлын хүрээнд Олон улсын автотээврийн холбооноос 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 10-ны өдрүүдэд “Аюултай ачаа тээвэрлэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэхийг Бодлого төлөвлөлтийн газар /Ж.Сэрээтэр/, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Батболд/-т тус тус даалгав" гэжээ. | | тухай" олон улсын конвенци, Жолоочийн болон тээврийн хэрэгслийн багийн ажил амралтын горимын тухай /AETR/ хэлэлцээр, мөн "Ачааг аюулгүй ачих буулгах технологи" сэдвээр үндэсний хэмжээнд 16 сургагч багшийг МАТНХ-той хамтран бэлтгэлээ.<br>Мөн UNECE болон Олон улсын Автотээврийн Холбоотой хамтран дээрх чиглэлээр чадавхийг бэхжүүлэх сургалтыг 2019-06 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулж, сургалтаар 30 хүнийг энэ чиглэлээр бэлтгэсэн.<br>"АТҮТ" ТӨҮГ-ийн Судалгаа, чанарын удирдлагын албатай хамтран энэ чиглэлийн судалгааны ажлыг хийж, сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулахаар 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр ТЗУГ-т хүргүүлсэн.<br>Тооцоог судалгааг хийж 2019.10.15-ны Сайдын зөвлөлийн 32 дугаар хурлаар оруулсан. Уг асуудлыг АТБХЗГ-аас Засгийн газрын хуралдаанаар оруулахаар болсон.<br>**АТБХЗГ:** Энэ ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн:<br>Олон улсын автозамын тээвэр гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн багийн ажлын талаарх Европын хэлэлцээр /AETR/-ийн эх хувийг ГХЯ-аар орчуулуулав.<br>Олон улсын автозамын тээвэр гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн багийн ажлын талаарх Европын хэлэлцээр /AETR/-ийн чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах техник туслалцааны төслийг хэрэгжүүлэх саналыг бэлтгэн, тус яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд Олон улсын автотээврийн холбооны 2019-02-28-наас 2019-03-02-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан хурлын үеэр НҮБЕЭЗК болон ОУАТХолбоонд танилцуулан, дэмжлэг хүссэн.<br>Үүний дагуу Олон улсын автотээврийн холбооноос 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 10-ны өдрүүдэд "Аюултай ачаа тээвэрлэх тухай" олон улсын конвенци, Жолоочийн болон тээврийн хэрэгслийн багийн ажил амралтын горимын тухай /AETR/ хэлэлцээр, мөн "Ачааг аюулгүй ачих буулгах технологи" сэдвээр үндэсний хэмжээнд 16 сургагч багшийг МАТНХ-той хамтран бэлтгэлээ.<br>Мөн НҮБЕЭЗК болон ОУАТХ-той хамтран "National TIR seminar"сургалтыг 2019-06-18-19-ний өдрүүдэд Монгол Улсад амжилттай зохион байгууллаа. Уг сургалтаар Тээврийн хэрэгслийн багийн ажил амралтын горим, Ногоон картын систем, ТИР тээвэрлэлт, eTIR чиглэлээр чадавхийг бэхжүүлж, нийт 35 хүнийг хамруулж, мэргэшүүлэв.<br>Дээрх олон улсын сургалтуудыг Монгол Улсад зохион байгуулахад нийт 210 сая төгрөгийн техникийн туслалцааны хүрээнд олон улсын байгууллагуудаас шийдвэрлүүлсэн ба дотоодын нөөц бололцооны хүрээнд 11 сая төгрөгийн зарцуулав. Нийт 46 хүнийг энэ чиглэлээр мэргэжил дээшлүүлэв.<br>Судалгааны ажил дуусгавар болгож, энэхүү олон улсын байгууллагын гишүүнчлэлд элсэх эсэх асуудлыг ЗТС-ын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж 33 тэмдэглэл гарсан. Тэмдэглэлд элсэх асуудлыг дэмжив. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т тус тус даалгав. | | Тус яамнаас гарсан шийдвэрийг 2019-05-28-ны өдрийн 07/2801 албан бичгээр дээрх компаниудад болон Татварын ерөнхий газарт хүргүүлсэн. Мөн дээрх шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 5 хуулийн этгээдэд автотээврийн хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлсэн. | |
| | | | 3. Улсын хуурамч дугаар хэрэглэж дугаарын хязгаарлалтаас чөлөөлөгдөж буй асуудал болон орон нутагт Улаанбаатар хотын харьяалалтай дугаар эзэмшиж буй зөрчлийг арилгуулах аяныг улсын хэмжээнд зохион байгуулж, үр дүнг 2019 оны эхний хагас жилд багтаан танилцуулахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Г.Гантулга/, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ /П.Дэлгэрнаран/ нарт тус тус даалгав” гэжээ. | Г.Гантулга /АТБХЗГ/ П.Дэлгэрнаран /АТҮТ ТӨҮГ/ | АТҮТ ТӨҮГ: Монгол улсын хэмжээнд **6216** тээврийн хэрэгсэл эзэмшигчийн хаягийн бүртгэл нь бүртгэлийн VRS системд олгогдсон улсын дугаартайгаа зөрүүтэй бүртгэгдсэн байна. Тус үйлдвэрийн газраас орон нутгийн Татварын хэлтэс, Тээврийн цагдаагийн хэлтэстэй хамтран орон нутагт Улаанбаатар хотын харьяалалтай дугаар эзэмшиж буй зөрчлийг арилгуулах аяныг улсын хэмжээнд зохион байгуулж дараахь ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд<br>✓ Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд аяны талаар танилцуулж, орон нутагт Улаанбаатар хотын харьяалалтай дугаар эзэмшиж буй зөрчлийг арилгах талаар албан мэдэгдэл хүргүүлсэн.<br>✓ Тээврийн цагдаагийн албаны даргын 2019 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн А/45 дугаар тушаалаар батлагдсан “Улсын дугаар-2019” нэгдсэн арга хэмжээнд тус үйлдвэрийн газрын гэрээт Зам, тээврийн цагдаагийн хэлтэс оролцож, 2019 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд хяналт, шалгалтыг ажлыг хамтран хийсэн. Тус хэлтэс нийт **5740** улсын дугаарын зөрчил илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн 17.7 дугаар зүйлд заасны дагуу арга хэмжээ авсан. Тус арга хэмжээний хүрээнд илэрсэн /улсын дугаар бүдгэрсэн, буруу байрлуулсан, улсын бүртгэлийн дугааргүй, эсвэл нуун далдалсан, хуурамч дугаартай замын хөдөлгөөнд оролцсон/ зэрэг зөрчлийг үйлдвэрийн газрын Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтэс арилгуулж ажилласан. | АТБХЗГ 70<br>АТҮТ 70 |
| 5 | 2019.03.07 №6 | Зам, тээврийн яам /хуучнаар/ болон “Ви Эйч Энд Би” ХХК, “Есүй ордон” ХХК-ийн түншлэл хооронд байгуулсан “Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга”, “Захиргааны барилга”, “Нисэх буудлын үйлчилгээний | “III.1. Зам, тээврийн яам /хуучнаар/ болон “Ви Эйч Энд Би” ХХК, “Есүй ордон” ХХК-ийн түншлэл хооронд байгуулсан “Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга”, “Захиргааны барилга”, “Нисэх буудлын үйлчилгээний барилга”-ын ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Энхболд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг холбогдох | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | барилга"-ын ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаар | албан тушаалтнуудад даалгав. Үүнд: | | | |
| | | | 1. Зам, тээврийн яам (хуучин нэрээр) болон "Ви Эйч энд Би" ХХК, "Есүй ордон" ХХК-ийн түншлэл хооронд байгуулсан "Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга", "Захиргааны барилга, "Нисэх буудлын үйлчилгээний барилга"-ын ажил гүйцэтгэх 133/14 дугаар гэрээ мөн Зам, тээврийн яам (хуучнаар) болон Барилгын хөгжлийн төв хооронд байгуулсан захиалагчийн хяналт хийх 135 дугаар гэрээний хэрэгжилтийг хөндлөнгийн аудит болон тус яамны хуулийн хэлтсийн төлөөллийг тус тус оролцуулан дүгнэж, дүгнэлтийг яаралтай Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т даалгав. | М.Энхболд /ХШҮДАГ/ | ИНЕГ ба Улаанбаатар-Аудит компанийн хооронд аудитын гэрээ байгуулагдсан.<br>ИНЕГ-аас санхүүжилтийг шийдвэрлэхээр судлаж байна.<br>ЗТХЯ-ны ажлын хэсэг Улаанбаатар-Аудит компанийн төлөөлөлтэй 2 удаа хуралдаж, ажлын даалгавар гарган, Яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.<br>Хөндлөнгийн аудитын дүгнэлт, ажлын хэсгийн тайланг сайдын зөвлөлийн хуралдаанаар 2019 оны 6 дугаар сарын 11-ний өдөр хэлэлцүүлсэн. | 100 |
| | | | 2. Дээрх гэрээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхэд хөндлөнгийн аудитыг оролцуулахтай холбогдон гарах зардлыг шийдвэрлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т даалгав." гэжээ. | Л.Бямбасүрэн /ИНЕГ/ | **ИНЕГ:** Хөндлөнгийн аудит хийх "Итгэлт Эстимейт" ХХК болон Грант Торн ХХК сонгогдож, ажил гүйцэтгэсэн.<br>Нийт аудитын төсөвт өртөг 9.9 сая төгрөг бөгөөд 4.95 сая төгрөгийн санхүүжилтийг ИНЕГ-аас олгосон.<br>Аудитын тайланг ирүүлээгүй байгаа тул үлдэгдэл санхүүжилтийг олгох боломжгүй байна. | 100 |
| 6 | 2019.03.07 №7 | Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын 2018-2021 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т тодотгол хийх тухай | 1. "Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын 2018-2021 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т тодотгол хийх асуудлыг хэлэлцээд дараах саналыг хүргүүлэхийг дэмжив. **Үүнд:**<br>Тодотгох төсөл арга хэмжээ<br>- Тавантолгой-Сайншанд чиглэлийн 447,7 км төмөр зам төслийг "Тавантолгой-Зүүнбаян | Ж.Сэрээтэр /БТГ/ | Үндэсний хөгжлийн газарт холбогдох баримт бичгийг бүрдүүлэн 2019 оны 03 сарын 14-ний 03/1131 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Хэрэгжилт-100% | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | чиглэлийн төмөр замын төсөл” болгон тодотгох<br>Хасах төсөл арга хэмжээ:<br>-Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ 2 төсөл;<br>-Алтанбулаг-Улаанбаатар - Замын үүд чиглэлийн хурдны замын төсөл.<br>Нэмэлтээр оруулах төсөл арга хэмжээ:<br>-Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замын төсөл;<br>-Алтай-Улиастай чиглэлийн 138 км хатуу хучилттай авто замын төсөл;<br>-Дорнод аймгийн Хэрлэн сум-Хавиргын боомт чиглэлийн 125.5 км хатуу хучилттай авто замын төсөл;<br>-Чойбалсан хотоос Ульхан хилийн боомт чиглэлд 233.48 км хатуу хучилттай авто зам барих төсөл;<br>-Ачааны вагон угсрах үйлдвэр байгуулах төсөл;<br>-Ховд аймгийн Ховд нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл /2019-2020он/;<br>-Чойбалсан-Хөөт чиглэлийн төмөр замын төсөл;<br>-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төсөл;<br>-Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төсөл;<br>-Улаанбаатар-Дархан чиглэлийн 204,6 км авто замын шинэчлэлийн төсөл.<br>2. “Монгол Улсын 2018-2021 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тодотгол хийх саналыг боловсруулж, холбогдох танилцуулга, тооцоо судалгааг нарийвчлан гаргаж, Үндэсний хөгжлийн газарт хүргүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Сэрээтэр/-т даалгав.” гэжээ. | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | 2019.03.29 №08 | “”Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн явцад 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар | “”Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн явцад 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар гаргасан санал, зөвлөмжийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Энхболд Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /Д.Мягмарсүрэн/, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Батболд/, Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т; | Д.Мягмарсүрэн /АТБХЗХ/ А.Батболд /ТЗДТБХЗГ/ Л.Бямбасүрэн /ИНЕГ/ М.Энхболд /ХШҮДАГ/ | **ИНЕГ:** Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тус газар хариуцах 4 зөвлөмж тусгагдсан бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлэхээр дараах арга хэмжээг авч байна. Үүнд:<br>1. Иргэний нисэхийн багц 35 дүрмийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019.06.12-ны өдрийн 187 дугаар тушаалаар батлуулж, улсын бүртгэлийн 1444-т бүртгүүлсэн. 8 ИНД-ийн төслийг (ИНД-91, 119, 129, 121, 125, 135, 133, 137) эцэслэн боловсруулж, хэлэлцүүлэг зохион байгуулахаар бэлтгэж байна.<br>Хелипортын стандартыг Стандарт хэмжил зүйн газрын "Иргэний нисэхийн стандартчиллын техникийн хороо"-ны 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. **“Аэродромын төлөвлөлт, ашиглалт, арчлалтын стандарт”**, “Аэродромын дизайнд тавигдах шаардлагууд”, **Аэродромын барилгын Норм ба дүрмийг** Зам, тээврийн салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 02-нд болох 4 дүгээр хурлаар хэлэлцүүлэхээр болсон.<br>2.Бодлогын баримт бичигт тусгагдсан хөрөнгө оруулалт шаардлагатай арга хэмжээнүүдийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх боломжийг эрэлхийлж байна. Мөн өөрсдийн нөөц боломжид тулгуурлан хэрэгжилтийг эхлүүлэх арга хэмжээг авч байна. **Тухайлбал:** Зам,тээврийн хөгжлийн сайдын 2 дугаар сарын 01-ний өдрийн 35 дугаар тушаалаар баталсан “ИНЕГ-ын 2011, 2013, 2015, 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн зарцуулагдаагүй үлдэгдэл хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д Өмнөговь аймаг нисэх буудлын агаарын хөлөг хөөрч буух зурвасын зураг, төсөл боловсруулахад **300.0** сая төгрөгийг, Дорнод нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвас шинэ зурвас байгуулах зураг, төсөл боловсруулахад **250.0** сая төгрөгийг тусгасан.<br>3. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн 2018 оны үр дүнг ИНЕГ-ын даргын зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 09-ны өдрийн 9 дүгээр хурлаар хэлэлцүүлж, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөр, журам, төлөвлөгөөг 2019 онд багтааж боловсруулж, батлуулах үүрэг өгсөн.<br>4. 2020 онд бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх хугацаа дуусч, хэрэгжилтэд үнэлгээ хийхтэй холбогдуулан бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээнүүдийн шалгуур үзүүлэлтийг /тоо, чанар, хувиар/ шинэчлэн тогтоож байна. | ТЗДТБХЗГ-70, АТБХЗХ-70, ИНЕГ-70<br><br>**Дундаж** 70 |
| | | | 2. “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн явцыг хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт тогтоосон хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг | | “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого” -ын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн, 2019.03.29-ны 09 дүгээр тэмдэглэл гаргуулан, бодлогын баримт бичгийн биелэлтийг хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт ЗГХЭГ-т 2019.03.29–ний өдрийн 01/1448 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /М.Энхболд/-т тус тус даалгав” гэжээ. | | | |
| 8 | 2019.03.29 №09 | “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр", “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр"–ийн хэрэгжилтийн явцад 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар | “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр", “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр"–ийн хэрэгжилтийн явцад 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар гаргасан санал, зөвлөмжийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Энхболд Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав.<br>**Үүнтэй холбогдуулан:**<br>1. Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /Д.Мягмарсүрэн/, Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т; | Д.Мягмарсүрэн /АТБХЗХ/<br>Л.Бямбасүрэн /ИНЕГ/ | 1.“Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийг шинэчлэх асуудлыг Иргэний нисэхийн аюулгүй байдлын Зөвлөлийн дэргэдэх нарийн бичгийн даргын ажлын албаны 2019.11.08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд, “Үндэсний хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулах ажлыг 2020 оны 1-3 дугаар улиралд зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Иймд Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн 17 дугаар хавсралтад орсон 16 дахь нэмэлт өөрчлөлтийг “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-т тусгаж батлуулах, ирэх онд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулах талаар тайлбарыг ЗТХЯ-ны АТБХЗХ-т 2019 оны 11 дүгээр сарын 08-ны 03/3855 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>2.Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр"-т хийсэн хяналт-шинжилгээний тайланд тусгагдсан эрчимжүүлэх шаардлагатай 8 заалт, хэрэгжилт үр дүнгүй 2 заалт, “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний тайланд тусгагдсан эрчимжүүлэх шаардлагатай 4 заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажлуудыг зохион байгуулсан.<br><br>4.“Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтүүдийг холбогдох байгууллагуудаас авч, улирал тутам нэгтгэн гаргаж байна. “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр” 97%, “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр” 93%-ийн хэрэгжилттэй. ИНАБҮХ, АТХҮХ-үүдийн хэрэгжилтийг гаргахдаа тодорхой тоо баримттай, огноотой, товч тодорхой бичиж байхад анхаарч, энэ оны хэрэгжилтийн тайланг гаргахдаа зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авсан. | **АТБХЗХ**-70<br>**ИНЕГ-**70 |
| | | | 2. “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр", “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр"–ийн хэрэгжилтийн явцыг хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт тогтоосон хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /М.Энхболд/-т тус тус даалгав” гэжээ. | М.Энхболд /ХШҮДАГ/ | “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр", “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр"–ийн хэрэгжилтийн явцыг хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | **ХШҮДАГ**-100 |
| 9 | 2019.04.17 №10 | “Далай ашиглах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын талаар | Сайдын зөвлөлийн гишүүдийн гаргасан санал, зөвлөмжийг тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Төмөр зам, далайн тээврийн | А.Батболд /ТЗДТБХЗГ/<br>Ж.Сэрээтэр /БТГ/ | Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх шийдвэр гарсан.<br>Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу ХЗДХЯ-ны 1-1/2593, СЯ-ны 6/3678 дугаартай албан бичгээр УИХ-д өргөн | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Батболд/, Бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Сэрээтэр/-т тус тус даалгав. | | мэдүүлэх зөвшөөрөл тус тус авч Засгийн газрын хэрэг эрхлэх газарт УИХ-д өргөн мэдүүлэхээр хүргүүлсэн.<br>УИХ-ын 2019 оны 75 дугаар тогтоолоор УИХ-ын намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалт батлагдсан бөгөөд Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл уг жагсаалтад орсон болно. | |
| 10 | 2019.04.17 №11 | “Төмөр замын тээврийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын талаар | Сайдын зөвлөлийн гишүүдийн гаргасан санал, зөвлөмжийг тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Батболд/, Бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Сэрээтэр/-т тус тус даалгав. | А.Батболд /ТЗДТБХЗГ/ Ж.Сэрээтэр /БТГ/ | Хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8-ийг үндэслэн 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/2633 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас, мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-ийг үндэслэн Сангийн яамнаас 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/2634 дугаар албан бичгээр тус тус хүссэн.<br>Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/2862, Сангийн яамнаас 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 6/3770 тус тус дугаар албан бичгээр хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг олгосон.<br>Тус зөвшөөрлийн дагуу Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн хуралдаанаар Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэхийн тулд хуулийн төсөл болон 14-н жагсаалт бүхий холбогдох 241 хуудас материалын бүрдлийг бэлтгэсэн.<br>Мөн төслийг хуулийн хэлтсийн даргаар хянуулж, засварлах шаардлагатай заалтуудыг дахин хянан боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох материалыг бэлтгэн 2019.08.02-ны өдрийн 01/4147 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нэр томъёоны тайлбарт нэмэлт оруулах болон зарим нэг зохицуулалт нэмэх шаардлагатай тул уг төслийг 2019.09.07-ны өдрийн 02/4720 албан бичгээр буцаан татсан. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11 | 2019.04.17 №12 | “Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 60 дугаар тушаалаар томилогдсон Ажлын хэсгийн “МИАТ” ТӨХК болон “Изинис Эйрвэйз” ХХК хооронд 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр байгуулсан 19/013, 19/17 тоот гэрээний талаар | “Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 73 дугаар тушаалаар томилогдсон Ажлын хэсгийн “МИАТ” ТӨХК болон “Изинис Эйрвэйз” ХХК хооронд 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр байгуулсан 19/013, 19/17 тоот гэрээний талаар гаргасан дүгнэлт, ажлын тайланг Ажлын хэсгийн гишүүн Зам, тээврийн хөгжлийн Сайдын орон тооны бус зөвлөх Б.Цогтгэрэл Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав.<br><br>Сайдын зөвлөлийн гишүүд ажлын хэсгийн гаргасан дүгнэлттэй танилцаад энэхүү гэрээний зарим заалтууд Иргэний хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Өрсөлдөөний тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн, Иргэний хуулийн 476.3-т заасан талуудын эрх, үүрэг, удирдлагын бүтэц, эрх, үүрэг, ашиг, алдагдлыг хуваарилах журам, гэрээнээс гарах журам, гэрээг дуусгавар болгох үндэслэл, дундын эд хөрөнгийг хуваарилах журмыг тусгаагүй, мөн зах зээлд ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй компаниуд нэгдмэл байдлаар үйл ажиллагаа явуулахаар тохиролцохдоо санхүүгийн хариуцлага, ашиг, алдагдлын хуваарилалт нь тодорхойгүй гэрээ байгуулсан нь ашиг сонирхлын зөрчилтэй, төрөөс үндэсний тээвэрлэгчийг дэмжиж ирсэн бодлоготой зөрчилдөж байна гэж үзлээ.<br><br>Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг | МИАТ ТӨХК | **МИАТ ТӨХК:** Хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын дагуу “МИАТ” ТӨХК нь “Изинис Эйрвейз” ХХК-тай 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр байгуулсан 19/013 тоот гэрээг цуцлах тухай мэдэгдлийг 2019 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр “Изинис Эйрвейз” ХХК-нд хүргүүлсэн ба нөгөө тал хүлээн зөвшөөрч, гэрээ цуцлагдсан болно.<br>Өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаар болон гэрээ цуцлах тухай мэдэгдлийн хуулбарыг ЗТХЯамны Д.Баярмаад 2019 оны 06 дугаар сарын 04-ний цахим шуудангаар илгээсэн болно. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | "МИАТ" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Р.Мэргэн/-д даалгав. Үүнд:<br><br>Ажлын хэсгийн гаргасан санал, зөвлөмжийг 14 хоногийн дотор хэрэгжүүлж, биелэлтийг Зам, тээврийн хөгжлийн сайдад танилцуулах;<br><br>1. Ажлын хэсгийн гаргасан санал, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т, Зам, тээврийн хөгжлийн сайдын орон тооны бус зөвлөх Б.Цогтгэрэл нарт даалгасугай. | | | |
| | | | 1. Ажлын хэсгийн гаргасан санал, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т, Зам, тээврийн хөгжлийн сайдын орон тооны бус зөвлөх Б.Цогтгэрэл нарт даалгасугай. | М.Энхболд /ХШҮДАГ/ | МИАТ ТӨХК-аас 6 сарын 4-ны өдөр email-ээр "МИАТ" ТӨХК болон "Изинис Эйрвэйз" ХХК хооронд 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр байгуулсан 19/013 тоот гэрээг цуцлах мэдэгдлийг 4 сарын 11-ны өдөр "Изинис Эйрвэйз" ХХК-д хүргүүлж, гэрээг цуцласнаа мэдэгдсэн. | 100 |
| 12 | 2019.05.30 №13 | Монгол-Сингапурын хамтарсан "Хөлөг онгоцны бүртгэл" компанийн талаар цаашид авах арга хэмжээний талаар | Монгол-Сингапурын хамтарсан "Хөлөг онгоцны бүртгэл" компанийн талаар цаашид авах арга хэмжээний талаар тус яамны харьяа Далайн захиргааны дарга С.Түвшинтөр Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав.<br>Танилцуулгатай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2019 оны 66 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг яаралтай гаргаж, тус асуудлыг Сайдын зөвлөлийн хуралдаанд дахин танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч, Зам, тээврийн хөгжлийн Сайдын зөвлөх Н.Амарсайхан, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Далай ашиглалт, усан замын | Д.Жавхлан /ТЗДТБХЗГ/ | Зам тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар Хөлөг онгоцны бүртгэлийн талаар цаашид авах арга хэмжээний тухай хэлэлцэж хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт гарган, Далайн захиргааны дарга болон Монголын хөлөг онгоц бүртгэлийн компанийн захиралд хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тээврийн хэлтсийн дарга Д.Жавхлан нарт тус тус даалгав. | | | |
| 13 | 2019.05.30 №14 | Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар | Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Мөнхтуяа Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав.<br>Сайдын зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган, тооцоо судалгааг нарийвчлан гаргаж Сайдын зөвлөлийн хуралдаанд дахин танилцуулахыг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /Д.Мягмарсүрэн/-т даалгав.” | Д.Мягмарсүрэн /АТБХЗХ/ | **АТБХЗХ:**<br>Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2019.03.15-ны өдрийн 01/1173 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>ЗТХСайдаар Б.Энх-Амгалан томилогдсонтой холбогдуулан хуулийн үзэл баримтлалыг дахин баталж Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Хууль зүй дотоод хэргийн яамны 2019.06.04-ний өдрийн 1-1/2594 тоот албан бичгээр баталж ирүүлснийг сайдын гарын үсэг, тамгаар баталгаажуулан 1 эх хувийг 2019.06.10-ны 01/3082 тоот бичгээр Хууль зүй дотоод хэргийн яаманд хувийг хүргүүлсэн болно.<br>Сангийн яам, Хууль зүй,дотоод хэргийн яамнаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгосон.<br>Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, төслийг сайжруулан дахин хэлэлцүүлэхээр тогтсон.<br>Сайдын зөвлөлийн гишүүдийн санал, чиглэл болон ХЗДХЯ, Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, саналыг нэгдсэн байдлаар редакцийн чанартай өөрчлөлт хийгдэж, саналыг тусгаж ажилласан.<br>Ажлын хэсэг нийт 4 удаа хуулийн төслийн хэлэлцүүллэгийг холбогдох байгууллагатай хийж, яамны www.mrtd.gov.mn вэб сайтад тухай бүр байршуулан хуулийн төсөлд санал авч ажилласан болно.<br>Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Сайдын зөвлөлийн хурлаар 2019 оны 11 сарын 29-нд хэлэлцүүлсэн ба хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. | 100 |
| 14 | 2019.05.30 №15 | Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажилд захиалагчийн хяналтын чиг үүргийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай | 1. Монгол Улсын Их Хурлын 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоол болон Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолоор Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбогдох хууль тогтоомж, олон улсын стандарт, чанарын шаардлагад нийцүүлэн барьж байгуулах ажлыг зохион байгуулахыг даалгасны дагуу тус төмөр замын барилгын ажилд захиалагчийн хяналтын чиг үүргийг төрийн | Б.Цэнгэл /МТЗ ТӨХК/ | МТЗ ТӨХК: Монгол Улсын Их Хурлын “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 73 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоол болон Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 2019 оны Н-05/05 дугаар зөвлөмж, Зам, тээврийн хөгжлийн Сайдын зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэл, Ерөнхий сайдын 2019 оны 53 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хуралдааны шийдвэр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 44 дүгээр тушаалаар байгуулагдсан Дэд ажлын хэсгийн 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар зөвлөмжийг үндэслэн төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болох “Тавантолгой төмөр зам” ХХК-ийг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн барилгын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Дээрх шийдвэрийн үндсэн дээр “Тавантолгой төмөр зам” ХХК-тай 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан АГГ-19/111104/33, АГ-01/08/01 дугаартай гэрээгээ байгуулан ажиллаж байна. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | өмчийн оролцоотой хуулийн этгээд болох “Тавантолгой төмөр зам” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зарчмын хувьд дэмжив.<br>Тус төмөр замын барилгын ажилд захиалагчийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ төмөр замын барилгын ажлын төсвийг хэмнэх зарчмыг үндэслэх, Ерөнхий сайдын 2019 оны 53 дугаар захирамжаар байгуулагдсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт танилцуулж, шийдвэрлүүлэхийг “Монголын төмөр зам” ТӨХК /Б.Цэнгэл/-д даалгасугай. | | | |
| | 2019.06.03<br>№16 | Тээврийн хэрэгсэл жолоочдох эрхийн болон мэргэшсэн жолоочийн эрх олгох сургалт, шалгалтын төв” байгуулах тухай | 1. Улаанбаатар хотод “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн эрх олгох сургалт, шалгалтын төв”-ыг “Жолоочийн дадлага, сургалтын ухаалаг систем”-ийг ашиглан төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэв.<br>2. “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн эрх олгох сургалт, шалгалтын төв”-ийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх талаар Үндэсний хөгжлийн газарт уламжлан шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Г.Гантулга/, Бодлого төлөвлөлтийн газар /Ж.Сэрээтэр/-т тус тус даалгав”. гэжээ. | Г.Гантулга /АТБХЗГ/<br>Р.Мэргэн /БТГ/ | **АТБХЗГ, БТГ:**<br>Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн эрх олгох сургалт, шалгалтын төв”-ийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтанд оруулахаар 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/1644 тоот, 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 01/4015 тоот албан тоотыг холбогдох материалын хамт Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн.<br>Мөн 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдөр ҮХГазартай ЗТС-ын бодлогын чиглэлээр хамтарсан уулзалт зохион байгуулсан бөгөөд уулзалтаар уг асуудлыг цаашид яаралтай шийдвэрлэх чиглэлээр санал солилцсон ба 2019 оны 4 дүгээр улиралд хийхээр төлөвлөсөн ажил 85 орчим хувийн хэрэгжилттэй байна.<br>Үүний зэрэгцээ Газрын асуудлын тухай 2019 оны 12 дугаар сарын 09-ны 07/6565 тоот албан тоотыг “Олон улсын худалдаа, логистикийн төв” ХК-д хүргүүлсэн. | 70 |
| | 2019.06.03<br>№17 | Зам, тээврийн хөгжлийн яам Бүс нутгийн хөдөлгөөний | “VII.1. Иргэний нисэхийн ерөнхий газрын “Бүс нутгийн хөдөлгөөний удирдлагын барилга”-ын талаар цаашид авах арга хэмжээний | Л.Бямбасүрэн /ИНЕГ/ | ИНЕГ:“Бүс нутгийн хөдөлгөөний удирдлагын барилга”-ын гэрээт ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр гэрээний нэмэлт, өөрчлөлт” гэрээг 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | удирдлагын барилга"-ын талаар цаашид авах арга хэмжээний талаар | талаар Иргэний нисэхийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга Б.Алтанцом Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав.<br>Иргэний нисэхийн ерөнхий газрын "Бүс нутгийн хөдөлгөөний удирдлагын барилга"-ын ажлыг цаашид үргэлжлүүлэхэд гүйцэтгэгч байгууллага болох "Үүрэг трейд" ХХК-ийн зүгээс төсөвт өртөгт дахин өөрчлөлт оруулахгүй талаар бичгээр баталгаа авч, тус компанитай байгуулах нэмэлт гэрээний төсөлд Сайдын зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган Сайдын зөвлөлийн хуралдаанд дахин танилцуулахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т даалгав." | | Гэрээнд "Үүрэг трейд" ХХК-ийн зүгээс төсөвт өртөгт дахин өөрчлөлт оруулахгүй талаар заалт оруулж, сайдын зөвлөлийн гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийг тусгасан. | |
| | 2019.06.03 №18 | Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн талаар | "VII.2. Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн талаар Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав. Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийн ашиглалтын талаар холбогдох эдийн засгийн тооцоо, судалгааг нарийвчлан гаргаж танилцуулахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т,<br>2. цаашид Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийн талаар авах арга хэмжээний саналыг боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс | Л.Бямбасүрэн /ИНЕГ/ | Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийн ашиглалтын тооцоо, дэлхийн зах зээлийн шатахууны үнэд үндэслэсэн агаарын хөлөгт 1 тн шатахуун сумлах үнийн тооцоог хийж, танилцуулга, судалгааг Зам, тээврийн хөгжлийн Дэд сайд болон ЗТХЯ-ны Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн даргад 2019 оны 8 дугаар сарын 12-ны өдөр танилцуулсан. | 70 |
| | | | | Д.Мягмасүрэн /АТБХЗХ/ | АТБХЗХ: ИНЕГ-т 2019.06.21-ний өдрийн 09/3357 тоот албан бичгээр 18 дугаар СЗХ-ийн шийдвэрийг хүргүүлсэн. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | /Д.Мягмасүрэн/-т тус тус даалгав.” гэжээ. | | | |
| | 2019.06.03 №19 | Хөшигийн хөндийн нисэх буудал” ТӨХХК-ийн талаар цаашид авах арга хэмжээний талаар | “VII.3. “Хөшигийн хөндийн нисэх буудал” ТӨХХК-ийн талаар цаашид авах арга хэмжээний талаар Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Р.Мэргэн Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав.<br>Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагаа албан ёсоор эхлэх хүртэлх хугацаанд тус компанийн зардлыг өсгөхгүй байх, хэмнэлтийн горимд шилжих чиглэл баримталж, “Хөшигийн хөндийн нисэх буудал” ТӨХХК-ийн 2019 оны үйл ажиллагааны зардлыг Иргэний нисэхийн ерөнхий газрын батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэх талаар санал боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /Д.Мягмасүрэн/-т тус тус даалгав. | Д.Мягмарсүрэн /АТБХЗХ/ | **АТБХЗХ:**<br>ХХНОБ ТӨХХК-ийн 2019 оны II улирлын үйл ажиллагааны санхүүжилтийг компанийн 2019.06.14-ний өдрийн хуралдаанаар хэлэцэн шийдвэрлэсэн.<br>Мөн компанийн 2019 оны үйл ажиллагааны санхүүжилтийн асуудлыг ЗТХЯ-ны 2019.07.23-ны өдрийн 01/3949 тоотоор ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын 2019.08.06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанаас гаргасан саналын дагуу Сангийн яам тус компанид зөвшөөрсний дагуу 2019.08.15-ны өдрийн 01/73 тоотоор ИНЕГ-ын батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлүүлэх саналаа ирүүлсэн.<br>ИНЕГ-аас ХХНОБ ТӨХК-ийн 2019 оны үйл ажиллагааны зардал болох 461 сая төгрөгийг санхүүжүүлэх саналыг тус яаманд ирүүлсэн.<br>ИНЕГ-аас 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр 200.0 сая төгрөг, 11 дүгээр сарын 20-ны өдөр 261.0 сая төгрөгийн санхүүжилтийг "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК-д тус тус олгосон.<br>Компанийн Хувьцаа эзэмшигчлийн хурлын 2019 оны 12 дугаар сард багтаан хуралдуулж, 2019 оны үйл ажилагааны тайлан, 2020 оны бизнес төлөвлөгөө, бүтэц орон тоо, хөрөнгө оруулалт, зорилтот түвшинг хэлэлцүүлэн шийдвэрлэх хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, удирдамжийг ЗТХсайдаар 2019.12.09-ний өдөр батлуулаад байна. | 100 |
| | 2019.06.11 №20 | Зам, тээврийн яам (хуучин нэрээр) болон “Ви Эйч энд Би” ХХК, “Есүй ордон” ХХК-ийн түншлэл хооронд байгуулсан “Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга”, “Захиргааны барилга, “Нисэх буудлын үйлчилгээний барилга”-ын ажил гүйцэтгэх 113/14 дугаар | “Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилга”, “Захиргааны барилга”, “Нисэх буудлын үйлчилгээний барилга”-ын ажил гүйцэтгэх 113/14 дугаар гэрээт ажлыг үндсэн гүйцэтгэгч болох “Ви Эйч Энд Би” ХХК-иар үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр шийдвэрлэв.<br>1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 92 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу гүйцэтгэгчид гэрээний хариуцлага тооцож, барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулах хугацааны нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, Сайдын зөвлөлийн гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийг тусган, гэрээний хугацааг сунгах | Д.Мягмарсүрэн /АТБХЗХ/ | АТБХЗХ: Сайдын зөвлөлийн хуралдаанааны шийдвэрийн дагуу захиалагч, гүйцэтгэгчийн хооронд 2019.07.24-ны өдөр 202 дугаар нэмэлт гэрээг байгуулан гэрээт ажлыг ашиглалтад оруулах хугацааг 2019.09.30-ний өдрийг хүртэл сунгаж, гүйцэтгэгчид 165 сая төгрөгийн алданги ноогдуулсан.<br>Гэрээт ажилд 2019.09.07-ны өдөр техникийн комисс ажилласан.<br>2019 оны 12 дугаар сарын байдлаар барилгын ажил бүрэн хийгдэж дууссан боловч улсын комисс ажиллах бичиг баримтын бүрдэл хангагдаагүй байна. Иймд Улсын комиссыг энэ 12 дугаар сард багтаан ажиллуулахаар гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, зөвлөх компаниудад үүрэг чиглэл өгч, гэрээт ажилд хяналт тавин, үлдэгдэл ажлыг шахах чиглэл өгч ажиллаж байна. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | гэрээ, Зам, тээврийн яам (хуучин нэрээр) болон Барилгын хөгжлийн төв хооронд байгуулсан захиалагчийн хяналт хийх 135 дугаар гэрээнүүдийн хэрэгжилтийн талаар | нэмэлт гэрээ байгуулахыг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /Д.Мягмарсүрэн/-т даалгав. | | | |
| | | | 2. Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа үйлдвэрлэлийн албадын 2019 оны орлого, зардлын төлөвлөгөөг батлах тухай” 305/313 дугаар тушаалын хүрээнд 113/14 дугаар гэрээний нэмэлт гэрээг Иргэний нисэхийн ерөнхий газар болон “Ви Эйч энд Би” ХХК хооронд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулж, барилга угсралтын ажлыг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ашиглалтад оруулахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т даалгав. | Л.Бямбасүрэн /ИНЕГ/ | **ИНЕГ:**<br>Төв аймгийн Засаг даргын 2018 оны А/571 дүгээр тушаалаар байгуулагдсан “Улсын комисс” захиргааны барилгыг ашиглалтад авсан.<br>Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга болон нисэх буудлын үйлчилгээний барилгын ажил 99% гүйцэтгэлтэй байна. ИНЕГ-ын даргын 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн А/709 дүгээр тушаалаар техникийн комисс томилогдож, техникийн үзлэгийг дээрх барилгуудад хийсэн.<br>2019 оны 12 дугаар сарын 16-нд Улсын комисс ажиллуулахаар төлөвлөж байна. 2019 онд 5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн. | 100 |
| | | | 3. Зам, тээврийн яам (хуучнаар) болон Барилгын хөгжлийн төв хооронд байгуулсан Ачаа шуудан тээврийн үйлчилгээний барилга, Захиргааны барилга, Нисэх буудлын үйлчилгээний барилгуудын барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт хийх 135 дугаар гэрээний хэрэгжилтийг дүгнэж, Сайдын зөвлөлийн гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийг тусган нэмэлт гэрээ байгуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /Д.Мягмарсүрэн/-т тус тус даалгав. | Д.Мягмарсүрэн /АТБХЗХ/ | **АТБХЗХ:**<br>Зам, тээврийн хөгжлийн яамны 2019.06.27-ны өдрийн 10/3489 тоот албан бичгээр “Грант Торнтон аудит” ХХК, “Итгэлт-Эстимэйт” ХХК-д шинжээчийн дүгнэлтийг дахин нягтлан ирүүлэхийг мэдэгдсэн. Одоогоор тус консорциумаас шинжээчийн дүгнэлтээ дахин ирүүлээгүй байна. | 30 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 4. Зам, тээврийн хөгжлийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газар болон “Грант Торнтон аудит” ХХК, “Итгэлт-Эстимэйт” ХХК-ийн хамтарсан консорциум хооронд зөвлөх үйлчилгээний 114 дүгээр гэрээг цуцалж, гэрээний хариуцлага тооцохыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т даалгав. | М.Энхболд /ХШҮДАГ/ | Урьдчилгаа 50 хувийн төлбөрийг төлсөн. Гэрээний үүргийг биелүүлээгүй тул үлдэгдэл санхүүжилтийг зөвлөх компанид өгөөгүй. | 70 |
| | 2019.06.11 №21 | “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийн талаар | 1. “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.<br><br>1.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эдийн засгийн тооцоо судалгааг нарийвчлан гаргаж, Сайдын зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган тус хөтөлбөрийг 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /Д.Мягмарсүрэн/-т даалгав. | Д.Мягмарсүрэн /АТБХЗХ/ | **АТБХЗХ:**<br>Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийг Засгийн газрын 2019.07.03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, "Хөтөлбөр батлах тухай" 283 дугаар тогтоолоор баталсан.<br>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан, ЗТХЯ-ны 2019.08.30-ны өдрийн 03/4611 тоотоор Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас санал авахаар хүргүүлэн санал авсан.<br>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ЗТХСайдын 2019.10.03-ны өдрийн “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 309 дүгээр тушаалаар баталсан.<br>2019.11.09-ны 09/5446 тоот албан бичгээр ИНЕГ-т хүргүүлсэн. | 100 |
| | | | 1.2. “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төслийг боловсруулан 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т даалгав”. гэжээ. | Л.Бямбасүрэн /ИНЕГ/ | **ИНЕГ:**<br>“Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 309 дугаар тушаалаар баталсан. | 100 |
| | 2019.06.11 №22 | Иргэний нисэхийн ерөнхий газрын “Бүс нутгийн | Иргэний нисэхийн ерөнхий газрын “Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга”-ын цаашид авах арга хэмжээний | Л.Бямбасүрэн /ИНЕГ | **ИНЕГ:**<br>“Бүс нутгийн хөдөлгөөний удирдлагын барилга”-ын гэрээт ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр гэрээний нэмэлт, өөрчлөлт” гэрээ 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хөдөлгөөний удирдлагын барилга”-ын талаар цаашид авах арга хэмжээний тухай | талаар Иргэний нисэхийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга Б.Алтанцом Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав. Танилцуулгатай холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т даалгав**. Үүнд:**<br><br>1. “Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга”-ын ажлыг гүйцэтгэх нэмэлт, өөрчлөлт оруулахдаа тус барилгын төсөвт өртөгт өөрчлөлт оруулахгүй байх, барилга угсралтын ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор барилгын ажлыг гүйцэтгэж дуусган, 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Техникийн болон Улсын комисст хүлээлгэн өгөх, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тус тус тодорхой тусган гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;<br><br>2. “Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга”-ын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-тай байгуулсан гэрээг дүгнэж, Сайдын зөвлөлийн гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийг тусган нэмэлт гэрээ байгуулахыг тус тус даалгав.” гэжээ. | | “Үүрэг трейд” ХХК-ийн зүгээс төсөвт өртөгт дахин өөрчлөлт оруулахгүй талаар заалт оруулж, Сайдын зөвлөлийн гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийг тусгасан.<br>ИНЕГ-ын даргын 2019 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А/750 дугаар тушаалаар Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилт, өдөр тутмын үйл ажиллагаа, батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах ажлын хэсэг томилогдсон.<br>Барилга угсралтын ажилд захиалагчийн талаас хяналтын инженер давхар томилсон.<br>2019 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар гадна ажил 98%-тай, дотор засал А, В,Д блок 90 хувьтай, нийт гүйцэтгэл 94%-тай байна.<br>“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-тай “Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга”-ын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх талаар гэрээ байгуулж байгаагүй. | |
| | | | | | **АТБХЗХ:**<br>“Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилга”-ын ажлыг “Үүрэг трейд” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд нийт гүйцэтгэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 91%-тай, одоогоор барилгын ажил зогссон байна.<br>Уг гэрээт ажлын явцын талаар 2019.06.03-ны өдөр Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулсан.<br>СЗХ-ын шийдвэрийг 2019.06.21-ний 09/3357 тоот бичгээр ИНЕГ-т хүргүүлсэн.<br>Мөн ИНЕГ-т 2019.06.25-ны өдрийн 03/3446 тоот албан бичгээр “чиглэл өгөх тухай” албан бичгээр холбогдох чиглэлийг өгч ажилласан.<br>2019,09,10-нд Дэд сайд Л.Халтарт барилгын ажлын явцын мэдээ болон санхүүжилтийн мэдээллийг ИНЕГ-аас гаргуулан цаасаар өгч танилцуулсан.<br>Дэд сайд болон АТБХЗХ-ийн дарга нар 2019,09,12-нд ИНЕГ-ын БНХТБ-ын үйл явцтай биечлэн танилцаж, ИНЕГ-ын удирдлагуудад холбогдох үүрэг, чиглэлийг шууд өгч ажиллаж, ажлын явцын мэдээллийг холбогдох удирдлагуудад танилцуулсан болно. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2019.06.18 №23 | Төвлөрсөн хангамжтай галт тэрэг угсрах төслийн тухай | 1. Төвлөрсөн хангамжтай галт тэрэг угсрах төслийн талаар хэлэлцээд дэмжих нь зүйтэй гэж үзэв.<br>1.1. Төвлөрсөн хангамжтай галт тэрэг угсрах төслийг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг, бүхий Ажлын хэсгийг байгуулж, төвлөрсөн хангамжтай галт тэрэг угсрах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, тайлагнан ажиллахыг Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам" нийгэмлэг /Д.Жигжиднямаа/-т даалгав | Д.Жигжиднямаа /УБТЗ ХНН/ | Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос зорчигчийн вагонд сайжруулсан шахмал нүүрс хэрэглэх, төвлөрсөн буюу цахилгаан халаалтай вагон угсрах ажлыг үе шаттайгаар зохион байгуулахыг Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлж, 2019 оны 09 дүгээр сарын 19-ний 19/17 тоот тогтоолоор шийдвэрлүүлсэн.<br>Сайдын зөвлөлийн шийдвэр, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны тогтоолыг тус тус хэрэгжүүлэх чиглэлийг 2019оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 08/5118 дугаар албан бичгээр "Улаанбаатар төмөр зам"-д хүргүүлэв.<br>"Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн даргад албан бичгээр сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэл өгсний дагуу ажлын төлөвлөгөө гарган, түүний дагуу ажиллаж байна. | 30 |
| | 2019.06.28 №24 | "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн талаар | "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга М.Энхболд Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав.<br>**Үүнтэй холбогдуулан:**<br>1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем/www.unelgee.gov.mn/-д байршуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар/М.Энхболд/-т, | ХШҮДАГ /М.Энхболд/ | "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем (www.unelgee.gov.mn)-д 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдөр байршуулсан. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд заасан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг харьяа агентлаг, байгууллагын удирдлагууд, яамны газар, хэлтсийн дарга нарт даалгав" гэжээ. | БТГ, АЗБХЗГ, ТЗДТБХЗГ, АТБХЗГ, АТБХЗХ, "МТЗ" ТӨХК, "УБТЗ" ХНН, Далайн захиргаа, "Нортерн рейлвейс" ХХК | БТГ-92.5%,<br>АЗБХЗГ-87.1%,<br>ТЗДТБХЗГ-91.4%,<br>АТБХЗГ-80%,<br>АТБХЗХ-88.9%,<br>"МТЗ" ТӨХК-70%,<br>"УБТЗ" ХНН-100%,<br>Далайн захиргаа-100%,<br>"Нортерн рейлвейс" ХХК- Үнэлэх боломжгүй. | 70 |
| | 2019.06.28 №25 | Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Зам, тээврийн хөгжлийн сайдад өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн талаар | "I. Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Зам, тээврийн хөгжлийн сайдад өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргаын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Энхболд Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. Дараах арга хэмжээг авч ажиллахыг харьяа агентлаг, байгууллагын удирдлагууд, яамны газар, хэлтсийн дарга нарт; | Яамны бүтцийн зургаан газар, нэг хэлтэс ба харьяа найман байгууллага | | |
| | | | 1.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан болон хавсралтад дурдсан хэрэгжилт хангалтгүй байгаа хөрөнгө оруулалт, санхүүжилт шаардагдахгүйгээр шийдвэрлэх боломжтой үүрэг, даалгаврыг ойрын хугацаанд хэрэгжүүлж дуусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах; | Яамны бүтцийн зургаан газар, нэг хэлтэс ба харьяа найман байгууллага | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан болон хавсралтад дурдсан хэрэгжилт хангалтгүй байгаа хөрөнгө оруулалт, санхүүжилт шаардагдахгүйгээр шийдвэрлэх боломжтой үүрэг, даалгаврыг ойрын хугацаанд хэрэгжүүлж дуусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар харьяа байгууллагууд дараах биелэлттэй ажилласан байна. **Үүнд:**<br>ТЗУГ-72.9, ХШҮДАГ-100, АЗБХЗГ-46.8, АТБХЗГ-52.6, ТЗДТБХЗГ-49.1, БТГ-26.0,, АТБХЗХ-54.5, "ЗТХТ" ТӨХК-42,4, "ИНЕГ"-12,5 хувийн хэрэгжилттэй байна.<br>Харин дараах харьяа байгууллагууд үр дүнтэй ажил хийсэнгүй. **Үүнд:**<br>"МТЗ" ТӨХК, "ГТХЗНТ" УТҮГ, "УБТЗ" ХНН, "ДАЛАЙН ЗАХИРГАА", "АТҮТ" ТӨХК, "МИАТ" ТӨХК | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 1.2. Хөрөнгө оруулалт, санхүүжилт шийдэгдээгүйгээс удаашралтай байгаа үүрэг, даалгаврыг хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулах; | Яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, хэлтэс | Хөрөнгө оруулалт, санхүүжилт шийдэгдээгүйгээс удаашралтай байгаа үүрэг, даалгаврыг хэрхэн шийдвэрлэх талаарх саналыг бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, хэлтэс боловсруулж байна. | 30 |
| | | | 2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулан ойрын хугацаанд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, төсөл, арга хэмжээний ажлыг эхлүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд/-д; | С.Батболд ТНБДарга | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжих 115 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс аймаг, орон нутагт эрх шилжсэн 75 төсөл, арга хэмжээ, ТӨБЗГ-аас хэрэгжүүлэх 19 төсөл, арга хэмжээ, ЗТХЯаманд худалдан авах ажиллагааг зохион байгуулах 21 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.<br>2019 онд ЗТХСайдын багцаас нийт 115 төсөл арга хэмжээ хэрэгжихээс 107 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулан гэрээ байгуулсан.<br>Бүх төсөл арга хэмжээний худалдан авалтын ажиллагаааг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн хүрээнд зохион байгуулсан болович 8 төсөл арга хэмжээн дээр хуулийн хүрээнд шаардлага хангасан оролцогч оролцоогүй тул хүчингүй болсон. | 100 |
| | | | 3. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Төрөөс баримтлах бодлого батлах тухай /“Авто замын салбарт төрөөс баримтлах бодлого”/, Журам батлах тухай /”Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”/, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Иргэний агаарын хөлөг, түүний эд анги, бүрэлдэхүүн хэсгийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай/ зэрэг эрх зүйн акт /дүрэм, журам, заавар, аргачлал/ бодлого, хөтөлбөр батлахаар эрх олгогдсон заалтуудад заасан дүрэм, журмыг шинэчлэх болон шинээр боловсруулах ажлыг | Д.Доржханд /АЗБХЗГ/<br><br>А.Батболд /ТЗДТБХЗГ/ | **АЗБХЗГ:**<br>Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамын дагуу төрөөс авто замын талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах хүрээнд суурь судалгааны ажлыг хэрэгжүүлсэн.<br>Бодлогын баримт бичгийн төслийн хувилбар боловсруулах хүрээнд АХБ-ны Техник туслалцааны төслөөр Шинэ Зелланд улсын иргэн Аллан Кейннанд зөвлөхийг сонгон шалгаруулсан.<br>Тус зөвлөх нь 2019 оны 1 дүгээр сараас 5 сарыг хүртэл хугацаанд ажилласан ба тус зөвлөх нь эцсийн тайлангаа бодлогын хувилбарын хамтаар боловсруулсан.<br>Тус бодлогын хувилбарыг авто замын салбарын төрийн болон хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд, их дээд, сургуулийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг 2019 оны 3, 4 дүгээр саруудад зохион байгуулж ажилласан. Бодлогын баримт бичгийн суурь судалгааны ажил болон гадаад зөвлөхөөс санал болгосон бодлогын хувилбарт үндэслэн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулсан.<br>Гэвч Монгол улсын Засгийн газраас “Монгол Улсыг урт хугацаанд хөгжүүлэх бодлого 2020-2045 он”-ыг боловсруулах шийдвэрийг гаргасан бөгөөд урт хугацааны бодлогын зорилго, зорилтыг боловсруулахдаа салбар хоорондын бодлогын уялдааг сайтар хангах зарчмын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргаас салбарын төрөөс баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг түр хойшлуулах чиглэл өгч тус ажлыг түр хойшлуулсан.<br><br>**ТЗДТБХЗГ:**<br>Хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8-ийг үндэслэн 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/2633 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас, мөн | АЗБХЗГ -Үнэлэх болом жгүй, ТЕДТБХ ЗГ - 70<br><br>Дундаж **70** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | эрчимжүүлж, 2019 оны III улиралд багтаан батлуулахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Батболд/-т; | | Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-ийг үндэслэн Сангийн яамнаас 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/2634 дугаар албан бичгээр тус тус хүссэн.<br>Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/2862, Сангийн яамнаас 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 6/3770 тус тус дугаар албан бичгээр хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг олгосон.<br>Тус зөвшөөрлийн дагуу Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн хуралдаанаар Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэхийн тулд хуулийн төсөл болон 14-н жагсаалт бүхий холбогдох 241 хуудас материалын бүрдлийг бэлтгэсэн.<br>Мөн төслийг хуулийн хэлтсийн даргаар хянуулж, засварлах шаардлагатай заалтуудыг дахин хянан боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох материалыг бэлтгэн 2019.08.02-ны өдрийн 01/4147 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нэр томъёоны тайлбарт нэмэлт оруулах болон зарим нэг зохицуулалт нэмэх шаардлагатай тул уг төслийг 2019.09.07-ны өдрийн 02/4720 албан бичгээр буцаан татсан. | |
| | | | 4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг тогтоосон хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн "Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем" /www.new.unelgee.gov.mn/-д байршуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /М.Энхболд/-т тус тус даалгав” | ХШҮДАГ /М.Энхболд/ | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2019 оны эхний хагас жилийн биелэлтийг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн тэмдэглэлийн хамт 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/3554 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /www.unelgee.gov.mn/-д 256 заалт нэг бүрийн хэрэгжилтийг бүрэн байршуулан ХШҮДАГ-ын даргаар баталгаажуулан ЗГХЭГ-т цахим болон цаасан хэлбэрээр тайлагнасан. | 100 |
| | 2019.06.28 №26 | “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд эхний хагас жилийн | “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга М.Энхболд Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан: | ХШҮДАГ /М.Энхболд/ | УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Зам, тээврийн хөгжлийн яамны хариуцан хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг 1 дүгээр улирлын байдлаар нэгтгэн, журамд нийцүүлэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлтийг хангуулах арга хэмжээний талаар санал, зөвлөмж гарган http://intranet.gov.mn сайтуудад байршуулсан.<br><br>Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийсэн тайланг нэгтгэн дүгнэж, яамны удирдлага, Сайдын зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанд танилцуулж, тэмдэглэлийн хамт ЗТХС-ын 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 02/3433 тоот албан бичгээр сангийн Сайдад хүргүүлж, | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн талаар | 1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Сангийн яаманд хүргүүлэн Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем/www.unelgee.gov.mn/-д байршуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар/М.Энхболд/-т, | | ЗГХЭГ-ын www.unelgee.gov.mn сайтад байршуулсан. Хэрэгжилт 70 хувьтай. | |
| | | | 2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд заасан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг харьяа агентлаг, байгууллагын удирдлагууд, яамны газар, хэлтсийн дарга нарт даалгав" гэжээ. | АЗБХЗГ<br>АТБХЗГ<br>ТЗДТБХЗГ<br>АТБХЗХ<br>ИНЕГ<br>"МТЗ" ТӨХК<br>"УБТЗ" ХНН<br>"Нортерн рейлвейс" ХХК<br>Төслийн нэгж<br>НЗДТГ | АЗБХЗГ-95.5%<br>АТБХЗГ-40%<br>ТЗДТБХЗГ-100%<br>АТБХЗХ-Үнэлэх боломжгүй<br>ИНЕГ- Үнэлэх боломжгүй<br>"МТЗ" ТӨХК- Үнэлэх боломжгүй<br>"УБТЗ" ХНН-100%<br>"Нортерн рейлвейс" ХХК- Үнэлэх боломжгүй<br>Төслийн нэгж-100%<br>НЗДТГ-82% | 70 |
| | 2019.08.15 №27 | Хөлөг онгоцны бүртгэлийн талаар цаашид авах арга хэмжээний тухай | Хөлөг онгоцны бүртгэлийн талаар цаашид авах арга хэмжээний тухай хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох дарга, захирал нарт үүрэг болгов. Үүнд:<br><br>1. Олон улсын далайн байгууллага /IMO/-ын аудитын байгууллагаас 2016 онд өгсөн зөвлөмжийн дагуу Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг Улаанбаатар хотод эрхлэн явуулах ажлыг "Далай ашиглах тухай хууль"-ийн 81 дүгээр зүйлийн 81.3 дахь хэсэгт заасны дагуу зохион байгуулахыг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/, Далайн захиргаа /С.Түвшинтөр/, | Б.Артур /ТЗДТБХЗГ/<br>С.Түвшинтөр /Далайн захиргаа/<br>Ч.Эрдэнэбат /Хөлөг онгоцны бүртгэл компани/ | **Далайн захиргаа:** Монголын хөлөг онгоцны бүртгэлд бүртгүүлэх талаар хөлөг онгоцны эзэмшигчээс гаргасан хүсэлтийг "Монголын хөлөг онгоцны бүртгэл" компани нь 2017 оны 10 дугаар сараас эхлэн Далайн захиргаанд цахимаар ирүүлдэг болсон.<br>Энэхүү хүсэлтийг хянан үзэж, Улаанбаатар боомтоос хөлөг онгоцонд бүртгэлийн дугаар олгож байна.<br>Зөвхөн 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар Улаанбаатар боомтоос 179 хөлөг онгоцонд шинээр бүртгэлийн дугаар олгоод байна. | ТЗДТБ ХЗГ -100, Далайн захир гаа -100, Хөлөг онгоц ны бүртгэл компани -100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Монгол-Сингапурын хамтарсан “Монгол хөлөг онгоцны бүртгэл”компани /Ч.Эрдэнэбат/-д; | | | |
| | | | 2. Далайн захиргааны үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, байгууллагын статусыг тодорхой болгож, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/, Далайн захиргаа /С.Түвшинтөр/-т; | Б.Артур /ТЗДТБХЗГ/ С.Түвшинтөр /Далайн захиргаа/ Ч.Эрдэнэбат /Хөлөг онгоцны бүртгэл компани/ | **ТЗДТБХГ:** Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, хуулийн төслийг Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу ХЗДХЯ-ны 1-1/2593, СЯ-ны 6/3678 дугаартай албан бичгээр УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл тус тус авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас УИХ-д өргөн мэдүүлэхээр хүргүүлсэн.<br>УИХ-ын 2019 оны 75 дугаар тогтоолоор УИХ-ын намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалт батлагдсан бөгөөд Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл уг жагсаалтад орсон болно.<br>**Далайн захиргаа:** Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Монгол Улсын Далайн захиргааг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Засгийн газар шийдвэрлэнэ” гэж, мөн хуулийн 6.2-т “Далайн захиргаа нь үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон далайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран баталсан нормативт хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулж, үлдэх хэсгийг ногдол ашиг хэлбэрээр улсын төсөвт төвлөрүүлнэ” гэж Сангийн яамны саналаар Далайн захиргааны эрх зүйн байдлыг аж ахуйн тооцоот төрийн өмчит үйлдвэрийн газар байхаар хуулийн төсөлд тусгасан.<br>Хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, УИХ-ын чуулганд өргөн барих асуудлыг Байнгын хорооны гишүүдийн олонхийн саналаар дэмжээд байна.<br>УИХ-ын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн чуулганд хуулийн төслийн үзэл баримтлалыг УИХ-ын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд танилцуулав.<br>Мөн УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцууллаа.<br>УИХын чуулганд оролцсон гишүүдийн 53,7%-ийн саналаар Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бусад холбогдох хуулийн төслийн хамт УИХ-ын чуулганаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзэв.<br>Энэхүү хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.<br>Мөн Хууль зүйн байнгын хороо хамтран ажиллахаар болов. | ТЗДТБ ХЗГ -100, Далайн захир гаа -100, Хөлөг онгоц ны бүртгэл компани -100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 3. Хөлөг онгоцны бүртгэлд тавигдах хяналтыг сайжруулах зорилгоор “Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн журам”-ыг шинэчлэхийг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/, Далайн захиргаа /С.Түвшинтөр/-т; | Б.Артур /ТЗДТБХЗГ/ С.Түвшинтөр /Далайн захиргаа/ | **Далайн захиргаа:** Монголын хөлөг онгоцны бүртгэлд тавигдах шаардлага, нөхцөлийг олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн тодорхой болгох зорилгоор “Монголын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам”-ын төслийг шинэчлэн боловсруулж, 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 1/213 тоот бичгээр ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т хүргүүлээд байна.<br><br>**ТЗДТБХЗГ:**<br>УИХ-аар “Усан замын тээврийн тухай хууль” батлагдахаар хүлээгдэж байгаа бөгөөд хууль батлагдсаны дараа энэхүү журмыг боловсруулан, батлуулахаар хүлээгдэж байна. | Далайн захиргаа 70, ТЗДТБХЗГ 70 |
| | | | 4. Монгол-Сингапурын хамтарсан “Монгол хөлөг онгоцны бүртгэл” компанийн банкинд харилцах дансыг нээлгэх асуудлыг яаралтай шийдвэрлэхийг Монгол-Сингапурын хамтарсан “Монгол хөлөг онгоцны бүртгэл”компани /Ч.Эрдэнэбат/-д тус тус даалгав. | Ч.Эрдэнэбат /Хөлөг онгоцны бүртгэл компани/ | **“Монголын хөлөг онгоцны бүртгэл” компани:**<br>Монгол-Сингапурын хамтарсан “Монголын хөлөг онгоцны бүртгэл” хамтарсан компанийн банкны харилцах дансыг эргүүлэн нээлгэх ажлын хүрээнд 2019 оны 07 дугаар сарын 09-өөс 10 дугаар сарын 25-ны хооронд Сингапур Улс дахь /CIMBank, HSBC bank, UOCBank, RHBBank/ банкуудад компанийн харилцах данс нээлгэхээр хүсэлт илгээж холбогдох баримт материалуудыг хүргүүлээд байна.<br>Дээрх банкуудаас HSBC банк бизнесийн харилцах дансны нэг жилийн мөнгөний эргэлтийн доод хэмжээ 3 сая ам. доллар буюу түүнээс дээш байх шаардлагад нийцэхгүй байна гэсэн хариу ирүүлээд байна.<br>CIM болон RHB банк нэмэлт материал ирүүлэхийг шаардсаны дагуу нэмэлт баримт бичгүүдийн хуулбарыг хүргүүлээд байгаа бөгөөд Банкны данс нээх талаар албан ёсны хариу ирүүлэхийг хүлээж байна.<br>UOC банкнаас албан ёсоор хариу ирүүлээгүй бөгөөд банкны хариуцсан хүмүүстэй нь утсаар холбогдоход “банкны данс нээх бичиг баримтын шалгалтын ажил үргэлжилж байна” гэсэн хариу өгөөд байна. | 70 |
| | 2019.08.15 №28 | “Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцын 2020 оны төсвийн төслийн талаар | 1. “Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцын 2020 оны төсвийн төслийг хэлэлцээд дэмжих нь зүйтэй гэж үзэв.<br>1.1 Сайдын зөвлөлийн гишүүдийн гаргасан санал, зөвлөмжийг тусган Сангийн яаманд хүргүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд/-д даалгав. | Р.Мэргэн /БТГ/ | Монгол Улсын 2020 оны Төсвийн хязгаар батлагдаж ирсэнтэй холбоотойгоор Зам тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын 2020 оны төсвийн багцад өгсөн харьяа байгууллага, газруудаас ирсэн саналыг нэгтгэж, сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.<br>Тус саналыг 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/4326 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн. | 100 |
| | 2019.08.15 №29 | Иргэний нисэхийн ерөнхий газрын | Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэх буудлуудын удирдах газар болон МИАТ ТӨХК-ийн хооронд 2019 оны 03 дугаар сарын 14-ний | Л.Бямбасүрэн /ИНЕГ/ Д.Баттөр /МИАТ ТӨХК/ | **МИАТ ТӨХК:**Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэх буудлуудын удирдах газар болон МИАТ ТӨХК-ийн хооронд 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан МИАТ 19/086 дугаартай “Агаарын хөлгийн | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нисэх буудлуудын удирдах газар болон МИАТ ТӨХК-ийн хооронд 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан МИАТ 19/086 дугаартай "Агаарын хөлгийн газрын үйлчилгээний тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний талаар | өдөр байгуулсан МИАТ 19/086 дугаартай "Агаарын хөлгийн газрын үйлчилгээний тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний талаар хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох дарга, захирал нарт үүрэг болгов.<br>**Үүнд:**<br>1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 215 дугаар тушаалаар томилогдсон Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэх буудлуудын удирдах газар болон МИАТ ТӨХК-ийн хооронд 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан МИАТ 19/086 дугаартай "Агаарын хөлгийн газрын үйлчилгээний тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлт болон "МИАТ" ТӨХК-иас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, тээврийн тарифыг бууруулах, дотоодын агаарын тээвэрлэгчдийг санхүүгийн алдагдалд оруулахгүй байх үүднээс Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэх буудлуудын удирдах газар болон МИАТ ТӨХК-ийн хооронд байгуулсан 2019 оны МИАТ 19/086 дугаартай "Агаарын хөлгийн газрын үйлчилгээний тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г цуцлахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэх буудлуудын | | газрын үйлчилгээний тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлэх гэрээ" цуцлагдсан болно.<br>Зам тээврийн хөгжлийн яамнаас 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 09/4592 тоот албан бичгээр Зам, Тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 29 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн МИАТ ТӨХК, Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэх буудлуудын удирдах газар хооронд 2019 оы 3 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан 19/086 тоот "Агаарын хөлгийн газрын үйлчилгээний тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлэх гэрээ" цуцлагдсан болно.<br>2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 80 хувийн хөнгөлөлттэй тарифаар үйлчлүүлэх талаар албан бичгийг 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэх буудлуудын удирдах газарт хүргүүлсэн.<br>2019 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн "МИАТ" ТӨХК 80 хувь, "Аэрофлот", "Кореан Эйр", "Эйр Чайна" компаниудад 70 хувийн хөнгөлөлттэй тарифаар тус тус үйлчлүүлэх талаар 01/4069 тоот албан бичгийг 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэх буудлуудын удирдах газарт хүргүүлсэн.<br>Түүнчлэн 2019 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн "МИАТ" ТӨХК 80 хувь, "Аэрофлот", "Кореан Эйр", "Эйр Чайна" компаниудад 70 хувийн хөнгөлөлттэй тарифаар тус тус үйлчлүүлэх, ЗТХ-ийн сайдын 29 дүгээр хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх талаар албан бичгийг 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэх буудлуудын удирдах газарт хүргүүлсэн.<br><br>**АТБХЗХ:**<br>ИНЕГ-ын Нисэх буудлуудын удирдах газар болон МИАТ ТӨХК-ний хооронд 2019,03,14-ний өдөр байгуулсан "Агаарын хөлгийн газрын үйлчилгээний тусгай зориулалтын автомашин тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлэх гэрээний" талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ЗТХС-ын 2019,06,21-ний өдрийн 215 дугаар "Ажлын хэсэг байгуулах" тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тайлан, дүгнэлт гаргасан.<br>ЗТХСайдын зөвлөл 209,08,15-ны өдрийн 29 дүгээр хуралдааны тэмдэглэл гаргаж. Хуучин үнэ тарифыг Хөшгийн хөндий дэх нисэх буудал руу шилжих хүртэл баримталж ажиллахыг ИНЕГ-т үүрэг болгосон.<br>ЗТХСайдын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг 2019.8.29-ны өдрийн 09/4592 тоот албан бичгээр ИНЕГ-т хүргүүлсэн. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | удирдах газар /Эрдэнэбаатар/, МИАТ ТӨХК /Д.Баттөр/-д; | | | |
| | | | 2. Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад орохтой холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газар Агаарын хөлгийн газрын үйлчилгээг хариуцан гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, боловсон хүчний судалгааг гаргаж танилцуулахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т тус тус даалгав.” | Л.Бямбасүрэн /ИНЕГ/ | **ИНЕГ:**<br>1.Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэх буудлуудын удирдах газар болон МИАТ ТӨХК-ийн хооронд 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан МИАТ 19/086 дугаартай “Агаарын хөлгийн газрын үйлчилгээний тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлэх гэрээ”- цуцлаж, хөнгөлөлттэй тарифаар үйлчилгээ үзүүлэхээр талууд харилцан тохиролцож, 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр У-19/55 дугаартай гэрээг шинэчлэн байгуулсан.<br>2.Хөшигийн хөндий дэх олон улсын шинэ нисэх буудалд Олон улсын стандарт, шаардлагад нийцсэн агаарын хөлгийн газрын үйлчилгээг дангаар гүйцэтгэхэд шаардлагатай үйл ажиллагааны чиглэл, машин, механизм, тоног төхөөрөмж болон боловсон хүчний судалгаа гаргаж, 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 01/3201 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. | 70 |
| | 2019.08.27 №30 | Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2019 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн талаар | “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2019 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга М.Энхболд Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан:<br>1. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Сангийн яаманд хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар/М.Энхболд/-т, | М.Энхболд ХШҮДАГ | “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2019 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн гаргаж, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-д нийцүүлэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлтийг хангуулах арга хэмжээний талаар санал, зөвлөмж гарган тайланг яамны удирдлагад танилцуулж http://intranet.gov.mn сайтад байршуулсан.<br><br>“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийсэн тайланг яамны удирдлага, Сайдын зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанд танилцуулж, тэмдэглэлийн хамт 2019.08.30-ны өдрийн 01/4616 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн. Хэрэгжилт 86.7 хувьтай. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд заасан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг харьяа агентлаг, байгууллагын удирдлагууд, яамны газар, хэлтсийн дарга нарт даалгав" гэжээ. | Яамны бүтцийн зургаан газар, нэг хэлтэс ба харъяа найман байгууллага | Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг жилд 1 удаа нэгтгэн дүгнэхээр заасан.<br>2020.09.01-ний өдрийн дотор ХШҮ хийх тул хугацаа болоогүй | Хугацаа болоо гүй |
| | 2019.10.15 №31 | Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилтэд 2019 оны 03 дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үнэлгээний талаар | Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилтэд 2019 оны гуравдугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Энхболд Сайдын зөвлөлийн гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан холбогдох газар, хэлтсийн дарга болон харьяа байгууллагуудын дарга захирал нарт дараах үүрэг даалгаварыг өгөв. Үүнд:<br><br>1. Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрээс 70 хувийн хэрэгжилттэй 21 арга хэмжээг 2019 оны жилийн эцэст бүрэн дуусгаж ажиллахыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг, байгууллагын дарга удирдлагуудад; | Яамны бүтцийн зургаан газар, нэг хэлтэс ба харъяа найман байгууллага | **ХШҮДАГ:**<br>Яамны бүтцийн 6 газар, 1 хэлтэст дараах албан тоотыг дотоод бичгээр хүргүүлж ажилласан. **Үүнд:**<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдааны №31 дугаартай тэмдэглэл (Тэмдэглэлийг хавсралт №1-ээр хүргүүлэв.)-ээр 70 хувийн хэрэгжилттэй арга хэмжээнүүд (70 хувийн хэрэгжилттэй арга хэмжээнүүдийн тоог харуулсан хүснэгтийг хавсралт №2-оор хүргүүлэв. ABLE-н "Олон нийт" цэсний файлын санд Яамны газар, хэлтсээс ирүүлсэн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг дэлгэрэнгүй байдлаар оруулсаныг үзнэ үү.)-ийг 2019 оны жилийн эцэст бүрэн дуусгаж ажиллах талаар өгсөн үүрэг, даалгаврыг үүгээр хүргүүлж байна.<br>2019 оны гуравдугаар улиралд 70 хувиар дүгнэгдэж байсан арга хэмжээнүүдийг нэмэгдүүлэх талаар харъяа байгууллагууд дараах байдлаар хийж гүйцэтгэсэн байна. **Үүнд:**<br>ТЗУГ-100, ХШҮДАГ-100, АЗБХЗГ-46.8, АТБХЗГ-52.6, ТЗДТБХЗГ-49.1, АТҮТ-70, БТГ-69.3, АТБХЗХ-54.5, "ЗТХТ" ТӨХК-42,4, "ИНЕГ"-12,5 хувийн хэрэгжилттэй байна.<br>Харин 2019 оны гуравдугаар улиралд 70 хувиар дүгнэгдэж байсан арга хэмжээнүүдийг нэмэгдүүлэх талаар дараах харъяа байгууллагууд үр дүнтэй ажил хийсэнгүй. **Үүнд:**<br>"МТЗ" ТӨХК, "ГТХЗНТ" УТҮГ, "УБТЗ" ХНН, "ДАЛАЙН ЗАХИРГАА", "АТҮТ" ТӨХК, "МИАТ" ТӨХК | Дундаж 70 |
| | | | 2. Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудын талаар болон цаашид хэрэгжүүлэх ажлуудын талаар Сайдын шуурхай хуралдаанд танилцуулахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т; | Л.Бямбасүрэн /ИНЕГ/ | Зам, тээврийн хөгжлийн сайдын 10 дугаар сарын 21-ний өдрийн шуурхай хуралдаанд танилцуулсан. | 100 |
| | | | 3. Нислэгийн хөдөлгөөний бүсийн удирдлагын шинэ төвийн байр, ачаа, шуудан тээврийн үйлчилгээ, захиргаа, нисэх буудлын үйлчилгээний барилга угсралтын | Л.Бямбасүрэн /ИНЕГ/ | 2019 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар г**адна ажил** 98%-тай, **дотор засал** А, В,Д блок 90 хувьтай, нийт гүйцэтгэл 94%-тай байна. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор бүрэн гүйцэтгэж, Улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэлийг бүрэн хангаж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т; | | | |
| | | | 4. Сайдын зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаас гарсан “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын дэргэд Зам, тээврийн салбарын судалгаа, шинжилгээний хүрээлэн байгуулах” шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгааг анхаарч 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн дотор бүрэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Сэрээтэр/, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ /Р.Буд/-т; | Э.Мөнхнасан<br>/БТГ/<br><br>Р.Буд<br>/ЗТХТ ТӨҮГ/ | **БТГ:**<br>Зам, тээврийн салбарын судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн дүрэм, бүтэц зохион байгуулалт, орон тоо, төсвийн төслийг дэмжээд АЗБХЗГ руу дотоод албан бичгээр хүргүүлсэн.<br>Тус дүрмийн төсөлд уг хүрээлэнг байгуулах асуудлыг Засгийн газраар шийдвэрлүүлэхээр санал тусгасан. Иймд тус яамны зүгээс уг асуудлаар дахин санал боловсруулж, Авто замын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүргийг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-т хариуцуулан ажиллуулах, тус газрын дүрэм, бүтцийг шинэчлэн батлуулахаар Монгол Улсын Засгийн газрын 2019.10.02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 42 дугаар тэмдэглэлийг гаргуулсан.<br>Тус яамнаас холбогдох шийдвэрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн тул ЗТХТ нь дүрэм, бүтэц, зохион байгуулалтандаа өөрчлөлт оруулж, үйл ажиллагаагаа эхлүүлэх шаардлагатай байна.<br><br>**ЗТХТ ТӨҮГ:**<br>Зам тээврийн салбарын эрдэм шинжилгээ судалгааны хүрээлэнгийн дүрэм, бүтэц, төсвийн төслийг  Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Улаанбаатар төмөр зам” ХНН, Иргэний нисэхийн ерөнхий газар, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн саналыг авсны үндсэн дээр боловсруулсныг 2019.04.02-ны 1/233 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.<br>Үүнийг ЗТХЯ-наас хянаж үзээд санал зөвлөмжөө ЗТХ-ийн дэд Сайдын 2019.04.17-ны 02/1879 тоот албан бичгээр ирүүлсэн. Санал зөвлөмжид “... *одоогийн төвийн бүтцэд байгаа орон тоон дээр ... шинээр авто тээвэр, иргэний нисэх, төмөр зам болон усан замын тээвэрт нэг орон тоог тус тус оруулаад нийт 20 эрдэм шинжилгээ, судалгааны ажилтантай байхаар зардлын тооцоог хийх*” гэсний дагуу судалгаа шинжилгээний 3 ажилтанг гэрээгээр авч ажиллуулахаар бүтэц, зардлын тооцоог дахин боловсруулан 2019.04.30-ны 1/301 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн болно. Үүний дагуу холбогдох харъяа байгууллага болон төвийн цахим хуудсанд 3 ажлын байрны орон тооны зар тавьж ажилласан боловч үндсэн шалгуур үзүүлэлтийг хангах хүн одоогоор ирээгүй байна. | БТГ<br>100,<br>ЗТХТ<br>70 |
| | | | 5. Сайдын зөвлөл, шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй | М.Энхболд<br>/ХШҮДАГ/ | **ХШҮДАГ:**<br>“Сайдын зөвлөлийн хуралдаан”-аас өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн газар, хэлтэс тэдгээрийн хэрэгжүүлж ажиллах арга | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох талаар санал боловсруулж, танилцуулж байхыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/, Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Болор-Эрдэнэ/-т; | Б.Болор-Эрдэнэ /ТЗУГ/ | хэмжээний нэрийг ХШҮДАГ-аас 2019.10.31-ны өдрийн дотоод бичгээр ТЗУГ-т хүргүүлсэн. | |
| | | | 5. Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийхдээ үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг ашиглах, тайланг товч, тодорхой бэлтгэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн санал, зөвлөмж боловсруулж танилцуулж байхыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т тус тус даалгав. | М.Энхболд /ХШҮДАГ/ | Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн дагуу ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтнүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг ашиглах, тайланг товч, тодорхой бэлтгэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн санал, зөвлөмж боловсруулж танилцуулж байхыг үүрэг болгосон. | 100 |
| | 2019.10.15 №32 | Олон Улсын Дэлхийн форумд нэгдэн орох тухай | 1. “Олон Улсын Тээврийн Форумд нэгдэн орох тухай” асуудлыг хэлэлцээд дэмжих нь зүйтэй гэж үзэв.<br>2. Тус Форумд нэгдэн орохтой холбогдуулан бэлтгэл ажлыг хангаж, нэгдэн орох үйл ажиллагааг зохион байгуулахыг Бодлого төлөвлөлтийн газар /Ж.Сэрээтэр/, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Г.Гантулга/-т тус тус даалгав” гэжээ. | Г.Гантулга /АТБХЗГ/ | “Олон Улсын Тээврийн Форумд нэгдэн орох тухай” ЗТС-ийн Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус байгууллагад хүргүүлсэн ба Монгол Улс Дэлхийн Тээврийн Форумд нэгдэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.<br>Элсэх эсэх асуудлыг Засгийн газрын 2020 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох төлөвлөгөөнд тусгасан. 2019 оны 4 дүгээр улиралд хийх бэлтгэл ажлын явц 80 орчим хувьтай байна.<br>Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд маш их судалгаа, тооцоо, хөрөнгө шаардлагатай тул урт хугацаанд хэрэгжинэ. | 70 |
| | 2019.10.15 №33 | Олон улсын авто замын тээвэр гүйцэтгэж буй тээврийн хэрэгсэлийн багийн ажлын талаар Европын хэлэлцээрт нэгдэн орох тухай | 1.Олон улсын авто замын тээвэр гүйцэтгэж буй тээврийн хэрэгсэлийн багийн ажлын талаарх Европын хэлэлцээрт нэгдэн орох тухай асуудлыг хэлэлцээд дэмжих нь зүйтэй гэж үзэв.<br>Тус хэлэлцээрт нэгдэн орохтой холбогдуулан бэлтгэл ажлыг хангаж, нэгдэн орох үйл | Г.Гантулга /АТБХЗГ/ | Олон улсын авто замын тээвэр гүйцэтгэж буй тээврийн хэрэгсэлийн багийн ажлын талаарх Европын хэлэлцээрийн төслийг орчуулаад байна. 2019 оны 4 дүгээр улиралд хийх бэлтгэл ажлын явц 70 орчим хувьтай байна.<br>Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд маш их судалгаа, тооцоо, хөрөнгө шаардлагатай тул урт хугацаанд хэрэгжинэ. | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагааг зохион байгуулахыг Бодлого төлөвлөлтийн газар /Ж.Сэрээтэр/, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Г.Гантулга/-т; | | | |
| | | | 2. Олон улсын тээвэрлэлт гүйцэтгэж буй автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний хянах нөхцөлийг бүрдүүлэхийг тус яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Г.Гантулга/, "Автотээврийн Үндэсний Төв" ТӨҮГ /Б.Гүрсоронзон/-т тус тус даалгав" гэжээ. | Г.Гантулга /АТБХЗГ/ Б.Гүрсоронзон /АТҮТ ТӨҮГ/ | **АТБХЗГ:** Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. 2019 оны 4 дүгээр улиралд хийх бэлтгэл ажлын явц 85 орчим хувьтай байна. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд маш их судалгаа, тооцоо, хөрөнгө шаардлагатай тул урт хугацаанд хэрэгжинэ. | 70 |
| | | | | | **АТҮТ ТӨҮГ:** Улс хоорондын дамжин өнгөрөх тээврийн хэрэгслүүдийг Монгол улсын нутаг дэвсгэрээр зорчих үед хяналт тавих зорилгоор үйлдвэрийн газрын 2020 оны зорилтот түвшинд 50 ширхэг зөөврийн байршил тогтоох төхөөрөмж худалдан авахаар тусгаж, ТӨБЗГ-т хүргүүлсэн. 2019 оны 4 дүгээр улиралд хийх ажлын явц 75 орчим хувьтай байна. | 70 |
| | 2019.10.15 №34 | "Олон улсын даатгалын ногоон картын систем"-ийн олон талт гэрээнд нэгдэн орох тухай | "Олон улсын даатгалын ногоон картын систем"-ийн олон талт гэрээнд нэгдэн орох тухай асуудлыг хэлэлцээд дэмжих нь зүйтэй гэж үзэв. Тус гэрээнд нэгдэн орохтой холбогдуулан бэлтгэл ажлыг ханган, нэгдэн орох үйл ажиллагааг зохион байгуулахыг Бодлого төлөвлөлтийн газар /Ж.Сэрээтэр/, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Г.Гантулга/-т тус тус даалгав" гэжээ. | Г.Гантулга /АТБХЗГ/ | "Олон улсын даатгалын ногоон картын систем"-ийн олон талт гэрээг орчуулах, Засгийн газрын гишүүдээс санал авахаар холбогдох материалуудыг бэлтгэж байна. 2019 оны 4 дүгээр улиралд хийх бэлтгэл ажлын явц 75 орчим хувьтай байна. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд маш их судалгаа, тооцоо, хөрөнгө шаардлагатай тул урт хугацаанд хэрэгжинэ. | 70 |
| | 2019.10.15 №35 | Зам, тээврийн хөгжлийн яамны тамга, тэмдэг түших албан тушаалтныг томилох талаар | Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар"-ын 37 дугаар заалтад "Тамга, тэмдгээ түших болон хэвлэмэл хуудсыг хариуцах хүнийг байгууллагын удирдлага томилно." гэж заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 113 дугаар тушаалаар батлагдсан "Зам, тээврийн хөгжлийн яамны албан хэрэг хөтлөлтийн журам"-д | Б.Болор-Эрдэнэ /ТЗУГ/ | Зам, тээврийн хөгжлийн яамны тамгыг Сайдын туслахд шилжүүлсэн. Журамд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | өөрчлөлт оруулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгав. гэжээ. | | | |

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**
АВТО ЗАМЫН САЛБАРЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР,
ТӨСЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ГАНТӨМӨР